



# ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

---

**АУДИТЫН КОД: БНА-2019/06-СА**

**“ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ”-Д  
ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН**

---

Баянхонгор хот 2019 он

**Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат**

Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

**Аудитын менежер А.Цэням**

Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn

**Ахлах аудитор: Б.Должмаа**

Утас: 88119345 Цахим хаяг: doljmaab@audit.gov.mn

**Аудитор: Б.Цэрэнчимэд**

Утас: 88302569 Цахим хаяг: tserenchimedb@audit.gov.mn

**Аудитор: Ж.Өсөхбаяр**

Утас: 99890393 Цахим хаяг: usuhuu83@yahoo.com

---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт  
мэдээллийг дараах хаягаар авна уу.

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

---

АГУУЛГА

АУДИТЫН ЗОРИЛТ, АРГА ЗҮЙ, СТАНДАРТЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ 2

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх.....2  
Аудитын зорилт.....2  
Аудитын хамарсан хүрээ .....2  
Аудитын арга зүй .....2  
Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт .....2  
Аудитыг гүйцэтгэсэн хугацаа, аудитын багийн бүрэлдэхүүн .....3  
Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдсан мэдээлэл, хэлэлцүүлсэн журам .....3  
Аудит хийхэд гарсан хүндрэл, бэрхшээл .....3  
Товчилсон үгийн тайлбар .....3

Үндсэн мэдээлэл .....4  
Гүйцэтгэлийн аудитын дүн .....6

**ТӨСВИЙН ОРЛОГЫГ ТӨЛӨВЛӨХДӨӨ ОРЛОГЫН БААЗ СУУРИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ТАЛААР ТООЦОО, СУДАЛГАА ХИЙХГҮЙГЭЭР, ӨМНӨХ ОНЫ ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛД ҮНДЭСЛЭЖ ТӨЛӨВЛӨДӨГ БАЙДАЛ ХЭВЭЭР ҮРГЭЛЖИЛСЭЭР БАЙНА. ....6**

1.1 Сангийн яамнаас ирүүлсэн чиглэл, удирдамжийн дагуу холбогдох тооцоолол, судалгаа хийлгүйгээр татварын орлогыг бодитой төлөвлөөгүй байна. ....6

1.2. Аймгийн ТЕЗ-ийн 2019 оны эхний хагас жилийн тайланд орлогын гүйцэтгэлийг үнэн зөв тайлагнаагүй байна. ....12

**БУУЦАГААН СУМЫН ЗДТГ-ЫН ХУУЧИН БАРИЛГЫГ ТӨСВИЙН 129.0 СЯА ТӨГРӨГИЙН ХӨРӨНГӨӨР ХУДАЛДАН АВСАН БОЛОВЧ ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ДАГУУ БҮРТГЭЭГҮЙ, АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР ХЯНАЛТ ТАВИАГҮЙГЭЭС ОРОН НУТГИЙН ӨМЧ ХӨРӨНГӨ ЭЗЭНГҮЙДЭХ, ҮРЭГДЭХ ЭРСДЭЛ ҮҮССЭН БАЙНА. ....18**

2.1. Аймгийн ТЕЗ-ийн 2019 оны төсвийн зарлагыг батлахдаа Сангийн яамнаас өгсөн “Орон нутгийн 2019 оны төсвийн төслийг боловсруулах, хэлэлцэн батлах, хэрэгжүүлэхэд баримтлах чиглэл, удирдамж”-ийг баримтлаагүй, Замын сангийн төсвийн зарлагыг санхүүжүүлэх эх үүсвэрээс 85.5 сая төгрөгөөр хэтрүүлэн, сумдын нийт зардлыг эх үүсвэрээсээ 243.4 сая төгрөгөөр дутуу баталсан байна. ....18

2.2. Аймгийн ТЕЗ-ийн эхний хагас жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланд зардлыг батлагдсан хөтөлбөр, арга хэмжээний дагуу үнэн зөв тайлагнаагүй байна. ....22

**ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙГ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛААГҮЙГЭЭС ЗӨРЧИЛ ДУТАГДАЛ ДАВТАГДАЖ ГАРСААР БАЙНА. ....25**

**АУДИТЫН ДҮГНЭЛТ .....27**

**АУДИТЫН ЗӨВЛӨМЖ .....29**

**Тайланг хянасан:**

**Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар**

**Дарга, тэргүүлэх аудитор**

**Б.Мөнхбат**

**Аудитын менежер**

**А.Цээням**

**Тайланг бэлтгэсэн:**

**Ахлах аудитор**

**Б.Должмаа**

**Аудитор**

**Б.Цэрэнчимэд**

**Ж.Өсөхбаяр**

**2019 оны 10 дугаар**

**сарын 08-ны өдөр**

**Уг тайланг УАГ-ын**

**Цахим хуудаснаас үзнэ**

**үү: [www.audit.mn](http://www.audit.mn)**

Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70442424 дугаарын утас, 70442584 дугаарын факсаар харилцана уу.

**ХАЯГ:**

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар  
Аймгийн ЗДТГ-ын байр,  
Баянхонгор сум,  
Баянхонгор аймаг-  
64000  
Монгол Улс

<b>Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх</b>	<b>Аудитын зорилт, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл</b> <p>Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2019 оны А/03 тоот тушаалаар батлагдсан “Үндэсний аудитын газрын 2019 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн аудитын төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулж, Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.</p>
<b>Аудитын зорилт</b>	<p>Монгол улсын төсвийн тухай хууль, Баянхонгор аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны эхний хагас жилийн төсвийн хэрэгжилтийн явцыг шалгаж, дүгнэлт, зөвлөмж гарган аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал болон төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэнэ. /<i>хавсралт №1</i>/</p> <ol style="list-style-type: none"><li>1. Аймгийн ТЕЗ-ийн 2019 оны төсвийн орлогыг бодитой төлөвлөж, төвлөрүүлсэн эсэх?</li><li>2. Аймгийн ТЕЗ-ийн 2019 оны батлагдсан төсвийг зориулалтын дагуу, үр дүнтэй зарцуулж буй эсэх ?</li><li>3. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан эсэх ?</li></ol>
<b>Аудитын хамарсан хүрээ</b>	<p>Аймгийн ТЕЗ-ийн 2019 оны эхний хагас жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлан, аймаг, сумдын ИТХ-ын хуралдааны тогтоол, аймгийн Засаг даргын захирамж, аймгийн Татварын хэлтсийн тайлан, Сангийн яамнаас Баянхонгор аймгийн 2019 оны аймгийн төсвийн суурь, орлого зарлагыг хянаж ирүүлсэн тооцоо болон бусад материалд тулгуурлан аудитыг гүйцэтгэв.</p>
<b>Аудитын арга зүй</b>	<p>Аудитыг гүйцэтгэхдээ төрийн хяналт, шалгалтын стандарт, гүйцэтгэлийн болон гүйцэтгэлийн аудитын удирдамж /АДБОУС 3000-3100/, Төрийн хяналт, шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журам, арга зүйг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа болон судалгаа, тайлан баримт материалд тулгуурлан харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэргээр аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.</p>
<b>Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт</b>	<p>Дараах хууль эрхийн актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"><li>• Төсвийн тухай хууль</li><li>• Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль</li><li>• Төрийн аудитын тухай хууль</li><li>• Төсвийн тухай хууль</li><li>• Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль</li><li>• Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль</li><li>• Татварын багц хуулиуд</li><li>• Шилэн дансны тухай хууль</li><li>• Аймаг, сумын ИТХ-ын хуралдааны тогтоолууд,</li><li>• Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн акт, стандарт</li></ul>

**Аудитыг гүйцэтгэсэн хугацаа, аудитын багийн бүрэлдэхүүн**

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын тэргүүлэх аудитор Б.Мөнхбат удирдаж, ахлах аудитор А.Цээням үе шатны ажлын чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Должмаа, аудитор Б.Цэрэнчимэд, Ж.Өсөхбаяр нар төлөвлөлтийн шатны ажлыг 2019 оны 08 дугаар сарын 22-ны өдрөөс, гүйцэтгэлийн шатны ажлыг 09 дүгээр сарын 04-ний өдрөөс эхлэн 09 дүгээр сарын 25-ны өдрийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэв.

**Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдсан мэдээлэл, хэлэлцүүлсэн журам**

Аудитын тайланг үндсэн мэдээлэл, аудитын дүн, аудитын дүгнэлт, зөвлөмж гэсэн агуулгаар бичиж, аудитын тайлангийн төслийг дарга, тэргүүлэх аудиторын зөвшөөрснөөр холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулан санал авч, тайлангийн эцсийн хувилбарыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн баталгаажуулж, аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга нар, аймгийн Татварын хэлтэст хүргүүлэв.

**Аудит хийхэд гарсан хүндрэл, бэрхшээл**

Сангийн яамны төсөвт байгууллагуудын Э-тайлангийн статистик тайлан хөрвөхгүй байсныг Сангийн яамнаас Э-Тайлангийн хөрвүүлсэн файлыг 2019 оны 09 дүгээр сарын 11-ний өдөр ирүүлсэн, аймгийн СТХС-ийн ахлах мэргэжилтэн, орлогын мэргэжилтэн нар ээлжийн амралттай байсан нь аудитыг цаг хугацаанд нь хийхэд хүндрэлтэй байсан болно.

### **Товчилсон үгийн тайлбар**

**АДБОУС**  
**АТӨЯХАТ**  
**ЖДҮ**  
**ЗДТГ**  
**ИТХ**  
**ОНӨ**  
**ОНӨГ**  
**ОНХС**  
**СТСХ**  
**СХС**  
**ТБОНӨХ**  
**ТБОНӨХБАҮХАТХ**  
**ТЕЗ**  
**ТЗШ**  
**УТХ**  
**ҮАГ**  
**ХОХБТХ**  
**ХХААГ**  
**ХХК**  
**ХХОАТ**  
**ЦХТАО**  
**ШШГГ**  
**ЭМТ**

Аудитын дээд байгууллагуудын Олон улсын стандарт  
Авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн албан татвар  
Жижиг дунд үйлдвэрлэл  
Засаг даргын Тамгын газар  
Иргэдийн төлөөлөгчдийн хурал  
Орон нутгийн өмч  
Орон нутгийн өмчийн газар  
Орон нутгийн хөгжлийн сан  
Санхүү төрийн сангийн хэлтэс  
Сум хөгжүүлэх сан  
Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгө  
Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль  
Төсвийн ерөнхийлөн захирагч  
Тусгай зориулалтын шилжүүлэг  
Улсын тэмдэгтийн хураамж  
Үндэсний аудитын газар  
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс  
Хүнс, хөдөө аж ахуйн газар  
Хязгаарлагдмал хариуцлагатай компани  
Хувь хүний орлогын албан татвар  
Цалин хөлс түүнтэй адилтгах орлого  
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар  
Эрүүл мэндийн төв

### **Хавсралт судалгаа**

**Судалгаа 1**  
**Судалгаа 2**  
**Судалгаа 3**  
**Судалгаа 4**

Орон нутгийн төсвийн төлөвлөлтийн судалгаа  
Орон нутгийн төсвийн орлогын судалгаа  
Баянхонгор аймгийн 2019 оны эхний хагас жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлан  
Харьяа байгууллагын 2019 оны эхний хагас жилийн орон тоо,

<b>Судалгаа 5</b>	цалингийн сангийн судалгаа
<b>Судалгаа 6</b>	Баянхонгор аймгийн ОНХС-ийн 2019 оны эх үүсвэрийн төлөвлөлт, бүрдүүлэлт
<b>Судалгаа 7</b>	Сум хөгжүүлэх сангийн орлого, зарлагын судалгаа
<b>Судалгаа 8</b>	Сумдын итх-ын хуралдаанаар баталсан тогтоолын эх үүсвэр, зардлын тулгалт
<b>Судалгаа 9</b>	Аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг сумдын ИТХ-ын тогтоолоор зөрүүтэй баталсан жагсаалт
<b>Судалгаа 10</b>	Аймгийн ТЕЗ-ийн 2019 оны батлагдсан төсөв
<b>Судалгаа 11</b>	Аймгийн ТЕЗ-ийн 2019 оны батлагдсан эх үүсвэр, төлөвлөлтийн программын зөрүү
	Аймгийн ТЕЗ-ийн 2019 оны батлагдсан зардал, төлөвлөлтийн программын зөрүү

## ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2018 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 14/03 тоот тогтоолоор аймгийн 2019 оны төсвийг 71284,9 сая төгрөгөөр баталсан ба аймгийн ИТХ-ын 2019 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн хуралдааны 16/02 тогтоолоор 2018 оны төсвийн үлдэгдлийн 629.6 сая төгрөгийг хуваарилж, тус хуралдааны “Аймгийн 2019 оны төсвийн хавсралтын зарим зардалд өөрчлөлт оруулах тухай” 16/03 тоот тогтоолоор аймгийн 2019 оны ОНХС-аас санхүүжих 100.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Цахилгаан халаагуураар Баянхонгор сумын иргэдийг хангах ажил”-ыг аймгийн ангилагдаагүй зардлаас санхүүжүүлэхээр өөрчлөлт оруулсан байна.

Сумдын ИТХ-ын тогтоолоор 2019 онд татварын орлогыг 2396.3 сая, хүү торгуулийн орлогыг 242.5 сая, төсөвт байгууллагын өөрийн орлогоор 31.9 сая, хандив тусламжийн орлогоор 235.0 сая, ОНХС-ийн орлогоор 263.3 сая, СХС-ийн зээлийн эргэн төлөлтийн орлогоор 1890.1 сая, бусад орлогоор 10.5 сая төгрөг оруулж, урьд оны үлдэгдлээс 2337.1 сая төгрөгөөр санхүүжихээр баталжээ.

Хүснэгт 1. Аймгийн ТЕЗ-ийн 2019 оны нэгдсэн төсөв

№	Үзүүлэлт	Сангийн яамны хянасан	Анх батлагдсан	Үлдэгдэл хуваарилсан	Нийт батлагдсан
А	Б	1	2	3	4
	<b>ИТХ-ын шийдвэрийн огноо, дугаар</b>		АИТХ-ын 2018.11.29-ны өдрийн 14/03, сумдын ИТХ-ын тогтоолууд	АИТХ-ын 2019.04.19-ны өдрийн 16/03	
<b>А</b>	<b>НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>72,000.4</b>	<b>78,691.5</b>	<b>629.6</b>	<b>79,321.1</b>
<b>1</b>	<b>УРСГАЛ ОРЛОГО</b>	<b>8,401.7</b>	<b>9,581.8</b>		<b>9,581.8</b>
<b>1.1</b>	Татварын орлого	7,456.9	8,608.3		8,608.3
<b>1.2</b>	Татварын бус орлого	944.8	973.5		973.5
<b>2</b>	<b>ХӨРӨНГИЙН ОРЛОГО</b>		<b>76.0</b>		<b>76.0</b>
<b>3</b>	<b>ХАНДИВ ТУСЛАМЖИЙН ОРЛОГО</b>		<b>585.0</b>		<b>585.0</b>
<b>4</b>	<b>ТУСЛАМЖИЙН ОРЛОГО</b>	<b>63,598.7</b>	<b>63,598.6</b>		<b>63,598.6</b>
<b>4.1</b>	Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	15,858.0	15,858.0		15,858.0
<b>4.2</b>	Улсын төсвөөс олгох ОНХС-ийн шилжүүлэг	6,485.9	6,485.9		6,485.9
<b>4.3</b>	Улсын төсвөөс шилжүүлэх тусгай зориулалтын шилжүүлэг	40,768.3	40,768.3		40,768.3
<b>4.4</b>	Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох шилжүүлэг	486.4	486.4		486.4
<b>5</b>	<b>БУСАД ЭХ ҮҮСВЭР</b>	<b>-</b>	<b>4,850.1</b>	<b>629.6</b>	<b>5,479.8</b>
<b>5.1</b>	Төсөвт байгууллагын өөрийн орлого		<b>2,284.8</b>		<b>2,284.8</b>
<b>5.2</b>	Бусад орлого		<b>10.5</b>		<b>10.5</b>
<b>5.3</b>	Өмнөх оны үлдэгдлээс санхүүжих		<b>2,554.9</b>	<b>629.6</b>	<b>3,184.5</b>

Аймгийн ТЕЗ-ийн 2019 оны төсвийн урсгал зардлыг 70587.3 сая, хөрөнгийн зардлыг 8612.8 сая, нийт зардлыг 79200.1 сая төгрөгөөр буюу эх үүсвэрээсээ 121.0 сая төгрөгөөр дутуу баталсан нь аймгийн Замын сангийн хөрөнгийн зардлыг эх үүсвэрээс 85.5 сая төгрөгөөр илүү, 10 сумын ИТХ төсвийн зардлыг эх үүсвэрээс 206.5 сая төгрөгөөр дутуу баталсантай холбоотой байна.

Аймгийн Засаг даргын 2019 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн А/233 тоот захирамжаар Санхүүгийн хяналт, аудитын албаны урсгал зардлын 3.5 сая төгрөгийн зардал хооронд гүйлгэн зарцуулах эрх олгож, мөн тусгай зориулалтын шилжүүлгийн 53 байгууллагын 851.6 сая төгрөгийн зардалд төсөвт зохицуулалт хийсэн байна.

Аймгийн ТЕЗ-ийн 2019 оны эхний хагас жилд урсгал зардалд 42538.7 сая, хөрөнгийн зардалд 4616.9 сая, нийт 47155.6 сая төгрөг зарцуулахаар төлөвлөж гүйцэтгэлээр 41445.9 сая төгрөг зарцуулсан байна.

Хүснэгт 2. Аймгийн ТЕЗ-ийн 2019 оны эхний хагас жилийн төлөвлөгөө, гүйцэтгэл /сая.төг/

№	Үзүүлэлт	2019 оны эхний хагас жилийн байдлаар		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
А	Б	2	4	5-4-2
<b>1</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>47,155.6</b>	<b>37,861.6</b>	<b>(9,294.1)</b>
<b>1.1</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>42,538.7</b>	<b>36,798.6</b>	<b>(5,740.1)</b>
<b>1.2</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>4,616.9</b>	<b>1,063.0</b>	<b>(3,554.0)</b>
<b>2</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>47,155.6</b>	<b>41,879.2</b>	<b>(263.2)</b>
<b>2.1</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>23,426.3</b>	<b>23,354.5</b>	<b>40.8</b>
2.1.1	Улсын төсвөөс санхүүжих	-	40.8	<b>40.8</b>
2.1.2	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	23,426.3	23,299.5	
2.1.3	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжтх	-	14.2	
<b>2.2</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>19,071.6</b>	<b>16,938.8</b>	<b>-</b>
2.2.1	Орон нутгийн төсвөөс	15,997.6	15,314.9	
2.2.2	Орон нутгийн хөгжлийн сангаас	3,074.1	1,623.9	
<b>2.3</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС САНХҮҮЖИХ</b>	<b>243.2</b>	<b>125.5</b>	<b>3.6</b>
2.3.1	НДС-ийн төсвөөс санхүүжих	-	3.6	<b>3.6</b>
2.3.2	ЭМД-аас санхүүжих	243.2	121.8	
<b>2.4</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС САНХҮҮЖИХ</b>	<b>4,414.5</b>	<b>1,460.4</b>	<b>(307.7)</b>
2.4.1	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,416.9	1,109.3	<b>(307.7)</b>
2.4.2	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	656.8	351.1	
2.4.3	Урд оны үлдэгдлээс санхүүжих	2,340.7	-	
<b>2.5</b>	<b>Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>2,593.9</b>	<b>2,593.9</b>
<b>2.6</b>	<b>Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>6,611.4</b>	<b>6,611.4</b>

## ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ДҮН

### БҮЛЭГ 1

Аймгийн ТЕЗ-ийн 2019 оны төсвийн орлогыг бодитой төлөвлөж, төвлөрүүлсэн эсэх?

**Төсвийн орлогыг төлөвлөхдөө орлогын бааз суурийг нэмэгдүүлэх талаар тооцоо, судалгаа хийхгүйгээр, өмнөх оны орлогын гүйцэтгэлд үндэслэж төлөвлөдөг байдал хэвээр үргэлжилсээр байна.**

**1.1 Сангийн яамнаас ирүүлсэн чиглэл, удирдамжийн дагуу холбогдох тооцоолол, судалгаа хийлгүйгээр татварын орлогыг бодитой төлөвлөөгүй байна.**

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулиар батлагдсанаар Баянхонгор аймгийн Засаг дарга Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний дагуу санхүүгийн дэмжлэгээр 15858.0 сая, тусгай зориулалтын шилжүүлэгээр 40768.3 сая, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 6485.8 сая, Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох шилжүүлгийг 486.4 сая, төсөвт байгууллагын өөрийн орлогоор 99.5 сая төгрөгийг хуваарилсан бөгөөд аймгийн ИТХ-ын хуралдааны 2018 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 14/03 тоот тогтоолоор аймгийн татварын болон татварын бус орлогоор 7369.0 сая төгрөгийг оруулж, нийт 71284.9 сая төгрөгийг төвлөрүүлэн зарцуулахаар төсөв батлагдсан байна.



Тусгай зориулалтын шилжүүлгээр эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээнд 6330.1 сая, ерөнхий боловсролын үйлчилгээнд 23409.2 сая, сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд 10069.7 сая, газрын харилцаа кадастрын үйлчилгээнд 462.3 сая, хүүхэд хөгжил хамгааллын

үйлчилгээнд 497.0 сая төгрөгийг зарцуулахаар баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2019 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн хуралдааны 16/02 тогтоолоор 2018 оны төсвийн үлдэгдлийн 629.6 сая төгрөгийг хуваарилсан байна.

Аймгийн төсвөөс сумдад олгох санхүүгийн дэмжлэгийг 13321.6 сая, ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 2821.3 сая, тусгай зориулалтын шилжүүлгийг 39381.7 сая, нийт 55524.6 сая төгрөгөөр, аймгийн төсөвт байгууллагуудад нийт 16475.5 сая төгрөгийн санхүүжилт олгохоор баталжээ.

**“ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ”-Д ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН**

Хүснэгт 3. Аймгийн ИТХ-аар батлагдсан төсөв

сая.төг

№	Орлого, зарлагын төрөл	Анх баталсан	Үлдэгдэл хуваарилсан	Нийт
<b>1</b>	<b>Аймгийн ТЕЗ-ийн нийт орлогын эх үүсвэр</b>	<b>71,284.9</b>	<b>629.6</b>	<b>71,914.6</b>
1.1	Аймгийн 2018 оны төсөвт төвлөрүүлэх орлого	7,369.0		7,369.0
1.2	Аймгийн төсөвт Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	15,858.0		15,858.0
1.3	Аймгийн төсөвт Улсын төсвөөс олгох Орон нутгийн хөгжлийн сангийн шилжүүлэг	6,485.9		6,485.9
1.4	Аймгийн төсөвт Улсын төсвөөс шилжүүлэх тусгай зориулалтын шилжүүлэг	40,768.3		40,768.3
1.5	Аймгийн төсөвт Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох шилжүүлэг	486.4		486.4
1.6	Аймгийн тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын өөрийн орлого	99.5		99.5
1.7	Аймгийн төсвийн урьд оны үлдэгдэл	217.8	629.6	847.4
<b>2</b>	<b>Аймгийн 2018 оны төсвийн жилд зарцуулах зарлагын хэмжээ</b>	<b>71,284.9</b>	<b>715.1</b>	<b>72,000.1</b>
2.1	Аймгийн ИТХ	583.9		583.9
2.2	Аймгийн Засаг даргын харьяаны байгууллага	70,701.0	715.1	71,416.1
<b>2.2.1</b>	<b>Сумдад</b>	<b>55,524.6</b>	<b>-</b>	<b>55,524.6</b>
2.2.1.1	Аймгийн төсвөөс сумын төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	13,321.6		13,321.6
2.2.1.2	Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас сумын Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг	2,821.3		2,821.3
2.2.1.3	Аймгийн төсвөөс 2018 оны төсвийн жилд сумдад олгох Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх тусгай зориулалтын шилжүүлэг	39,381.7		39,381.7
<b>2.2.2</b>	<b>Баянхонгор аймаг</b>	<b>15,176.5</b>	<b>715.1</b>	<b>15,891.6</b>
2.2.2.1	Аймгийн ЗДТГ	2,058.3		2,058.3
2.2.2.2	Аймгийн Засаг даргын Ерөнхий данс	2,636.6	355.6	2,992.2
2.2.2.3	Автозамын сан	706.1	198.6	904.7
2.2.2.4	Санхүүгийн хяналт аудитын алба	143.6		143.6
2.2.2.5	Орон нутгийн өмчийн газар	167.5		167.5
2.2.2.6	Байгаль орчин, аялал жуулчлалын газар	497.1		497.1
2.2.2.7	Сум дундын ойн анги	73.8		73.8
2.2.2.8	Ахмад настны асрамжийн газар	119.8		119.8
2.2.2.9	Халамжийн сан	151.5	45.0	196.5
2.2.2.10	Хот тохижилт-Үйлчилгээ ОНӨГ газар	691.2		691.2
2.2.2.11	Гадаад харилцаа, аялал жуулчлалын алба	80.0		80.0
2.2.2.12	Аймгийн Орон нутгийн хөгжлийн сан	3,571.4	115.9	3,687.3
2.2.2.13	Аймгийн тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллага	4,279.6		4,279.6
	<b>НИЙТ ТЭНЦЭЛ</b>	<b>-</b>	<b>(85.5)</b>	<b>(85.5)</b>

**Аудитын илрүүлэлт:**

Замын сангийн 2018 оны харилцах дансны үлдэгдэл нь 198.6 сая төгрөг байхад урьд оны үлдэгдлээс санхүүжих эх үүсвэрийг аймгийн ИТХ-ын хуралдааны 2018 оны 14/03, 2019 оны 16/03 тоот тогтоолуудаар 284.4 сая төгрөгөөр баталж 85.5 сая төгрөгийн алдагдалтай төсөв баталсан нь Төсвийн тухай хуулийн 57.2<sup>1</sup>, 57.3<sup>2</sup> дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Харин сумдын 2019 оны төсвийн нийт эх үүсвэр 62931.1 сая төгрөг байхад зарим зардлыг бүрэн тусгаагүй, тооцооллыг алдаатай хийсэн зэргээс шалтгаалж төсвийн нийт



зардлыг 62687.7 сая төгрөгөөр буюу 243.4 сая төгрөгөөр зөрүүтэй баталжээ. Иймд

<sup>1</sup> 57.2.Орон нутгийн төсвийг алдагдалгүй төлөвлөн баталж, хэрэгжүүлнэ.

<sup>2</sup> 57.3.Орон нутгийн төсвийн урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх зарлагыг төсөвт тусган баталж хэрэгжүүлэх ба зарлага нь санхүүжүүлэх эх үүсвэрээсээ хэтрэхгүй байна.

уг зөрчлийг арилгах арга хэмжээ авч ажиллах албан шаардлагыг аймгийн СТСХ-т хүргүүлээ.

**Аудитын илрүүлэлт:**

• Сумдын ИТХ-ын тогтоолоор баталсан зардлын дүн санхүүжүүлэх эх үүсвэрээсээ 243.4 сая төгрөгөөр дутуу баталсан ба Галуут, Жинст, Эрдэнэцогт, Заг сумдын ИТХ-ын хуралдаан сумын төсвийг 200.6 сая төгрөгөөр алдагдалтай баталж Төсвийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2<sup>3</sup> дахь заалтыг зөрчсөн байгаа нь төлөвлөсөн зардал, арга хэмжээ хэрэгжихгүй тасрах эрсдэл үүсэхээр байна.

№	Сумын нэр	Аймгийн ИТХ-ын тогтоолоор			Сумын ИТХ-ын тогтоолоор				Зөрүү
		Санхүүгийн дэмжлэг	ТЗШ	ОНХС	Сумын орон нутгийн орлого	Урьд оны үлдэгдлээс	НИЙТ ЭХ ҮҮСВЭР	НИЙТ ЗАРЛАГА	
1	Баянбулаг	519.3	1,065.4	73.4	86.8	217.7	1,962.6	1,737.8	224.8
2	Баянлиг	724.2	1,805.8	227.0	184.3	194.4	3,135.7	3,083.3	52.4
3	Баян-Овоо	491.0	832.7	72.0	520.3	93.6	2,009.5	1,848.4	161.1
4	Баянцагаан	462.8	1,248.6	144.5	217.2	17.0	2,090.0	2,089.4	0.6
5	Галуут	568.3	1,522.6	96.3	184.8	131.5	2,503.5	2,506.0	(2.5)
6	Гурванбулаг	518.4	1,229.9	88.8	155.1	46.7	2,038.8	2,037.8	1.0
7	Жинст	520.2	959.4	99.5	153.8	8.1	1,740.8	1,848.0	(107.1)
8	Заг	526.8	957.8	66.2	80.5	95.3	1,726.7	1,727.7	(1.0)
9	Шинэжинст	548.5	1,152.7	486.6	252.1	109.4	2,549.3	2,545.0	4.2
10	Эрдэнэцогт	697.5	1,341.3	76.3	83.2	1.4	2,199.7	2,289.7	(90.0)
<b>ДҮН</b>		<b>5,577.0</b>	<b>12,116.1</b>	<b>1,430.6</b>	<b>1,918.0</b>	<b>914.9</b>	<b>21,956.7</b>	<b>21,713.2</b>	<b>243.4</b>

Өмнөх аудитаар илэрсэн татварын орлогын төлөвлөгөөг төсвийн төлөвлөлтийн программд үнэн зөв оруулдаггүй, аймгийн Татварын хэлтэст зөрүүтэй мэдээлдэг, сумдын ИТХ-аас баталсан тогтоолууд нь зөрүүтэй зэрэг зөрчлүүд арилаагүй аудитаар давтагдан гарсаар байна. Тухайлбал:

- Сумдын ИТХ-аар баталсан 2019 оны татварын орлогын дүн 2396,2 сая төгрөг байхад төсвийн төлөвлөлтийн программд 2195.8 сая төгрөгөөр буюу 200.4 сая төгрөгөөр зөрүүтэй оруулсан байна. Энэ нь сумын ИТХ-ын тогтоол батлагдаагүй байхад аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн орлогын мэргэжилтэн аймгийн ИТХ-аар баталсан дүнгээр татварын орлогыг төсвийн төлөвлөлтийн программд оруулсантай холбоотой байна.
- Баянхонгор сумын ИТХ-ын хуралдаанаар хадгаламжийн хүүгийн орлогыг 450.0 сая, хүү торгуулийн орлогыг 122.1 сая төгрөгөөр баталсан байхад аймгийн СТСХ нь хадгаламжийн хүүгийн орлогыг 472.0 сая төгрөгөөр буюу 22.0 сая төгрөгөөр илүү, хүү торгуулийн орлогыг 100.1 сая төгрөг буюу 22.0 сая төгрөгөөр дутуу Татварын хэлтсийн төлөвлөгөөнд тусгасан байна.
- Аймгийн ИТХ-ын хуралдаанаар баталсан аймгийн төсвийн татварын орлогыг Баянбулаг, Баян-Овоо, Богд, Галуут, Заг, Хүрээмарал зэрэг сумд сумын төсөв баталсан тогтоолоор баталж байгаа нь Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.26<sup>4</sup> дахь заалтыг зөрчиж байна.
- Аймгийн төсвөөс сумын төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийг аймгийн ИТХ-аар 13321.6 сая төгрөгөөр баталсан байхад Баянбулаг сум 47.6 сая, Галуут сум 2.5 сая, Гурванбулаг, Жинст, Заг, Эрдэнэцогт сум тус бүр 1.0 сая төгрөгөөр санхүүгийн дэмжлэгийг зөрүүтэй баталсан.
- Аймгийн ИТХ-ын хуралдааны тогтоолоор Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх тусгай зориулалтын шилжүүлгийн хэмжээг Галуут суманд 1522.6 сая төгрөг баталсан байхад сумын ИТХ-ын тогтоолоор тус шилжүүлгийн хэмжээг 1298.8 сая төгрөгөөр зөрүүтэй буюу 223.8 сая төгрөгөөр баталсан.

<sup>3</sup> 57.2.Орон нутгийн төсвийг алдагдалгүй төлөвлөн баталж, хэрэгжүүлнэ.

<sup>4</sup> Засаг даргын өргөн мэдүүлснээр сум, дүүргийн төсвийг хэлэлцэж батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлах;

Дээрх зөрчлүүдийн талаар төсвийн төлөвлөлтийн программд татварын орлогын төлөвлөгөөг оруулсан аймгийн СТСХ-ийн орлогын мэргэжилтэн Б.Жамьяндоржоос тодруулахад “сумын ИТХ-аар төсөв батлагдаж ирэхээс өмнө төсвийн төлөвлөлтийн программд төсвийг оруулсан байсан ба оруулсны дараа сумын ИТХ-аар төсөв нэмэгдэж батлагдаж ирснийг төсвийн төлөвлөлтийн программд нөхөн дараа нь оруулсан байгаа, энэ өөрчлөлтийг сангийн яамны программ татаагүй байна” гэсэн тайлбарыг өгч байгаа боловч энэ нь ажил хариуцсан мэргэжилтний хариуцлагагүй, программд мэдээллийг хугацаанд нь оруулаагүйтэй холбоотой гэж үзэж байна.

Сумдын ИТХ-ын тогтоолоор орон нутгийн орлогоор 7406.6 сая төгрөгийн орлого оруулахаар төлөвлөж, аймгийн ТЕЗ-ийн 2019 оны төсвийн эх үүсвэрийг 79321.1 сая, төсвийн зардлыг 79163.2 сая төгрөгөөр батлагдсан байхад аймгийн СТСХ-ийн мэргэжилтнүүд Сангийн яамны төсвийн төлөвлөлтийн программд 79351.1 сая төгрөгөөр оруулсан байна.

Хүснэгт 4.. Аймаг, сумдын ИТХ-ын тогтоолоор батлагдсан орлого, эх үүсвэрийг төсвийн төлөвлөлтийн программд оруулсан зөрүү сая.төг

№	НИЙТ ОРЛОГО	Аймгийн ИТХ-ын тогтоолоор	Сумдын ИТХ-ын тогтоолоор	Нийт батлагдсан	Сангийн яамны төсвийн төлөвлөлийн программын дүн	Зөрүү
A	Аймгийн ТЕЗ-ийн нийт орлогын эх үүсвэр	71,914.6	7,406.6	79,321.1	79,351.1	(29.9)
1	Орон нутгийн орлого	7,369.0	2,873.8	10,242.8	26,679.2	(578.5)
1.1.	Татварын орлого	6,212.0	2,396.3	8,608.3		
1.2.	Хүү, торгуулийн орлого	731.0	242.5	973.5		
1.3.	Хандив тусламжийн орлого	350.0	235.0	585.0		
1.4.	Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	76.0	-	76.0		
2	Аймгийн төсөвт Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	15,858.0	-	15,858.0		
3	Аймгийн төсөвт Улсын төсвөөс олгох ОНХС-ийн шилжүүлэг	6,485.9	-	6,485.9	6,485.9	0.0
4	Аймгийн төсөвт Улсын төсвөөс шилжүүлэх тусгай зориулалтын шилжүүлэг	40,768.3	-	40,768.3	40,778.3	(10.0)
5	Аймгийн төсөвт Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох шилжүүлэг	486.4	-	486.4	486.4	-
6	Төсөвт байгууллагын өөрийн орлого	99.5	2,185.3	2,284.8	2,431.1	(146.3)
7	Бусад орлого		10.5	10.5		10.5
8	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	847.4	2,337.1	3,184.5	2,490.2	694.3

Аймгийн 2019 оны орон нутгийн орлогыг өмнөх оноос 1139.0 сая төгрөгөөр бууруулж, 12538.0 сая төгрөгийн орлого оруулахаар төлөвлөсөн нь 2019 онд уул, уурхайн аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг зогсоосноос хандив тусламжийн орлогыг бууруулж, ЖДҮ-ийн зээлийг “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-д шилжүүлснээс зээлийн эргэн төлөлтийн орлогыг төлөвлөөгүй зэрэгтэй холбоотой байна.

Хүснэгт 5. Орон нутгийн орлогын төлөвлөгөө сая.төг

№	Орлогын төрөл	2018 он	2019 он	Өөрчлөлт
A	Аймгийн ТЕЗ-ийн нийт орлогын эх үүсвэр	13,677.0	12,538.0	(1,139.0)
1	Татварын орлого	7,823.4	8,608.3	784.8
2	Татварын бус орлого	821.0	973.5	152.5
3	Төсөвт байгууллагын өөрийн орлого	2,032.3	2,284.8	252.5
4	Хандив тусламжийн орлого	2,350.3	585.0	(1,765.3)
5	ЖДҮ-ийн зээлийн эргэн төлөлт	100.0	-	(100.0)
6	Бусад орлого	-	10.5	10.5
7	ОНӨ-ийн хөрөнгө борлуулсны орлого	550.0	76.0	(474.0)

1.1.1. Аймаг, сумдын ИТХ-ын хуралдаанаар татварын орлогыг өмнөх оноос 652.1 сая, Сангийн яамны хянасан дүнгээс 998.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 2019 онд 8608.3 сая төгрөг оруулахаар төлөвлөсөн байна.

Хүснэгт 6. Татварын орлогын төлөвлөгөө

сая.төг

Орлогын төрөл	2017 оны гүйцэтгэл	2018 онд Сангийн яамны хянасан	2018 оны төлөвлөгөө	2018 оны гүйцэтгэл	2019 онд Сангийн яамны хянасан	2019 оны төлөвлөгөө	Өөрчлөлт	
							Өмнөх оны төлөвлөгөөнөөс	Сангийн яамны хянаснаас
<b>Татварын орлогын дүн</b>	8,940.5	6,511.5	7,956.1	8,222.2	7,610.0	8,608.3	652.2	998.3
<b>1.Аймгийн нэгдсэн төсөв төсөв</b>	5,302.6	4,670.0	5,007.4	5,288.8	5,281.9	5,399.0	391.6	117.1
а. ЦХТАО /суутган-1/	5268.70	4800.00	5050.00	5101.70	5252.8	5,253.0	203.0	0.2
б. Хувь хүний орлогын буцаан олголт	-771.40	-800.00	-800.00	-656.60	-800.0	-800.0	0.0	0.0
в. АТӨЯХАТ	399.70	370.00	433.00	441.40	420.0	426.0	-7.0	6.0
г.Газрын төлбөр	158.00	120.00	124.00	118.60	160.0	270.0	146.0	110.0
д. Үл хөдлөх хөрөнгийн татвар	247.60	180.00	200.40	283.70	249.1	250.0	49.6	0.9
<b>2. Орон нутгийн төсөв</b>	3,637.9	1,841.5	2,948.7	2,933.4	2,328.1	3,209.3	260.6	881.2
<b>Хүн амын орлого</b>	2038.7	1160.5	1227.0	1601.0	1306.5	1458.5	231.5	152.0
1. Үйл ажиллагааны орлого /ИОТТХ/	632.3	400	451.5	482.1	308.0	381.0	-70.5	73.0
2. Үл хөдлөх хөрөнгө борлуулсны татвар	<b>405.5</b>	<b>65</b>	<b>80</b>	<b>0.7</b>	<b>96.1</b>	<b>100.0</b>	20.0	<b>3.9</b>
3. Хөрөнгийн орлого /Хадгаламжийн хүү/	<b>948.2</b>	<b>650</b>	<b>650</b>	<b>1063</b>	<b>855.9</b>	<b>928.0</b>	278.0	<b>72.1</b>
4. Бууны татвар	<b>52.7</b>	<b>45.5</b>	<b>45.5</b>	<b>55.2</b>	<b>46.5</b>	<b>49.5</b>	4.0	<b>3.0</b>
<b>5. Бусад төлбөр хураамж</b>	<b>1,599.20</b>	<b>681.00</b>	<b>1,721.70</b>	<b>1,332.40</b>	<b>1,021.60</b>	<b>1,750.80</b>	<b>29.10</b>	<b>729.20</b>
а.Улсын тэмдэгтийн хураамж	231.7	215	237	247.9	270.0	273.3	36.3	3.3
б. Газрын дуудлага худалдааны орлого	0	0	200		0.0	150.0	-50.0	150.0
в. Орон нутгийн зам ашигласны төлбөр	0	0	147.8	0	0.0	194.6	46.8	194.6
г. Хог хаягдлын үйлчилгээний хураамж	301.9	0	308.5	314.8	300.0	506.2	197.7	206.2
д.ус рашаан ашигласны төлбөр	438.8	250	400	264.6	200.0	253.3	-146.7	53.3
е.Түгээмэл тархацтай АМАТөлбөр	8.4	9	12	12	12.0	25.7	13.7	13.7
ё.Ан, амьтан агнуурын нөөц ашигласны	602.9	200	407.9	468.5	239.6	339.5	-68.4	99.9
ж.Нохойны татвар	8.9	7	8.5	8.9	0	8.2	-0.3	8.2
з.Бусад татвар	6.6	0	0	15.7	0	0	0.0	0.0

**Аудитын илрүүлэлт:**

Аймгийн Засаг даргын баталсан “2019 оны улс, орон нутгийн төсвийн татварын орлогын төлөвлөгөөний хуваарь”-т дээрх татварын орлогын нийт дүнг 8630.2 сая төгрөгөөр буюу 22.0 сая төгрөгөөр зөрүүлсэн нь Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1.а<sup>5</sup> дахь заалтыг зөрчиж байна. Энэ нь Баянхонгор сумын ИТХ-ын хуралдаанаар баталсан 450.0 сая төгрөгийн хадгаламжийн хүүгийн орлогыг 472.0 сая төгрөгөөр хуваарилж зөрүү 22.0 сая төгрөгийг хүү торгуулийн орлогоор хуваарьт баталсан байна.

Сангийн яамны хянасан татварын орлогын дүнг 998.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөсний 700.0 сая төгрөг нь аймгийн Төрийн аудитын газраас 6 төрлийн татварын орлогыг нэмэгдүүлэх саналыг аймгийн ИТХ-д өгсний дагуу нэмэгдүүлсэн байна.

Төсвийн орлогыг төлөвлөхдөө орлогын бааз суурийг нэмэгдүүлэх талаар тооцоо, судалгаа хийхгүйгээр, өмнөх оны орлогын гүйцэтгэлд үндэслэх төдийгөөр төлөвлөж байна.

<sup>5</sup> а/нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн зорилт болон жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, гүйцэтгэлийн тайлан, орон нутгийн төсвийн болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлуулахаар тухайн Хуралд оруулах, батлагдсан хөтөлбөр, төсөв, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

**Аудитын илрүүлэлт:**

- Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын судалгааг бүх сумдаар гаргаагүй, 2018 онд татварын орлого 83.3 сая төгрөгөөр давсантай холбоотой 2019 оны орлогыг 49.6 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.
- Хог хаягдлын хураамжийн орлогыг 2019 онд бүх сумдаас авах болсонтой холбоотой тус орлого өмнөх оноос 197.7 сая төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд 4 сумын ИТХ батлаагүй байхад орлогыг төлөвлөсөн.
- Үйл ажиллагааны орлогыг өмнөх оноос 70.5 сая төгрөгөөр бууруулан төлөвлөсөн талаар төсвийн мэргэжилтэн тайлбар хийгээгүй болно.
- Сангийн яамнаас Зам тээврийн хөгжлийн яам, Авто тээврийн үндэсний төв, Татварын албаны нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн тээврийн хэрэгслийн зөрүүг нягталж төлөвлөлтийг хийх чиглэл ирүүлсэн байхад аймгийн СТХС-ийн орлогын мэргэжилтэн судалгаа хийгээгүй атлаа өмнөх онд 433.0 сая төгрөгөөр төлөвлөж, 8.4 сая төгрөгөөр давсан АТӨЯХАТ-ыг 2019 онд 426.0 сая төгрөгөөр баталж 6.0 сая төгрөгөөр бууруулж баталсан.
- Аймгийн Татварын хэлтсээс ирүүлсэн галт зэвсгийн судалгаан дээр үндэслэн бууны албан татварыг тооцсон гэх боловч аудитаар тус судалгааг татварын төлөвлөсөн дүнтэй тулган шалгахад Баянбулаг сумын татварыг 440.0 мянга, Богд сумын татварыг 180.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн бол Бууцагаан сумын татварыг 200.0 мянга, Жаргалант сумын татварыг 510.0 мянган төгрөгөөр бууруулан баталжээ.

1.1.2. Аймгийн ИТХ-ын хуралдааны 2018 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 14/03 тоот тогтоолоор хүү торгуулийн орлогыг 731.0 сая, сумдын ИТХ-ын хуралдааны тогтоолоор 242.5 сая, нийт 973.5 сая төгрөгөөр оруулахаар төлөвлөсөн байна.

Хүснэгт 7. Хүү, торгуулийн орлогын төлөвлөгөө сая.төг

Орлогын төрөл	2018 оны төлөвлөгөө	2018 оны гүйцэтгэл	2019 онд Сангийн яамны хянасан	2019 оны төлөвлөгөө	Өөрчлөлт	
					Өмнөх оны төлөвлөгөөнөөс	Сангийн яамны хянаснаас
Хүү торгууль	821.0	989.6	924.1	973.5	152.5	49.4

Аудитаар сумын ИТХ-ын хуралдааны тогтоолыг тулган шалгахад сумдын ИТХ-ын хуралдааны тогтоолоор нэмж баталсан 48.5 сая төгрөгийн хүү торгуулийн орлогыг аймгийн СТХС-ийн орлогын мэргэжилтэн Сангийн яамны төсвийн төлөвлөлтийн программд дутуу оруулсан зөрчил илэрлээ.

**Аудитын илрүүлэлт:**

- Баацагаан, Бууцагаан, Галуут сум тус тус 3.0 сая, Баянговь сум 1.0 сая, Баян-Овоо сум 12.0 сая, Баянхонгор сум 22.1 сая, Жаргалант сум 2.1 сая, Шинэжинст сум 2.3 сая төгрөгөөр хүү торгуулийн орлогыг нэмэгдүүлж баталсныг орлогын мэргэжилтэн төсвийн төлөвлөлтийн программд оруулсан боловч татагдаагүй байна гэсэн тайлбарыг өгч байгаа болно. Иймд сумын ИТХ-аар эцэслэж баталсан тогтоолыг нэгтгэж, төсвийн төлөвлөлтийн программд үнэн зөв оруулж байх, холбогдох буруутай албан тушаалтанд хариуцлага тооцож ажиллах зөвлөмжийг аймгийн ЗДТГ-ын СТСХ-т хүргүүлэв.
- Баянхонгор сумын ИТХ-ын хуралдааны 2018 оны 11/7 тоот тогтоолоор хууль, тогтоомжийн дагуу сумын төсөвт орох бусад татварын орлогоор 6.0 сая төгрөгийг баталсан байхад аймгийн СТХС уг татварыг орхигдуулж, аймгийн татварын орлогын мэдээнд оруулаагүй.

Хандив тусламжийн орлогоор 2018 онд 319.4 сая төгрөг орсон ба аймгийн ИТХ-ын хуралдааны 2019 оны төсөв баталсан тогтоолоор тус орлогыг 350.0 сая төгрөг оруулахаар төлөвлөжээ.


1.1.3. Аймгийн ИТХ-ын хуралдааны 2018 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 14/06 тоот тогтоолоор орон нутгийн өмчид бүртгэлтэй 8 үл хөдлөх хөрөнгийг худалдан борлуулах шийдвэр гарсан байхад дээрх хөрөнгүүдийн худалдах доод үнийг тогтоогоогүй, хэдэн төгрөгөөр борлуулах урьдчилсан судалгаа хийлгүйгээр төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсан орлогыг 2019 онд 76.0 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.

**Аудитын илрүүлэлт:**

*Дээрх орлогоос 26.0 сая төгрөгийг аймгийн ЗДТГ-аас оруулахаар аймгийн ИТХ-ын 2018 оны 14/03 тоот тогтоолоор баталсан боловч байгууллагын төсвийн хуваарь дээр байхгүй байгаа тул цаашид алдааг давтан гаргахгүй байх талаар анхаарч ажиллах шаардлагатай байна.*

1.1.4. Сангийн яамнаас орон нутгийн 2019 оны төсвийн төслийг боловсруулах, хэлэлцэн батлах, хэрэгжүүлэхэд баримтлах чиглэл, удирдамжид “Соёл урлагийн байгууллагуудын үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг батлахгүй ба уран бүтээл туурвиж орсон орлогыг ажилтнуудын нийгмийн баталгааг хангахад шаардлагатай зардалд бие даан зарцуулах эрхтэй байна” гэж заасны дагуу Баацагаан, Баян-Овоо, Баянговь, Хүрээмарал, Жаргалант, Өлзийт сумдын соёлын төвөөс бусад соёлын байгууллагууд өөрийн орлогыг төлөвлөөгүй байна.

Аймгийн ТЕЗ-ийн харьяаны байгууллагуудын өөрийн орлогоор 2019 онд 2284.8 сая төгрөг баталсны 82.7 хувь нь сумдын СХС-ийн зээлийн эргэн төлөлтийн орлого, 11.5 хувь нь ОНХС-ийн орлого, 5.8 хувь нь 12 төсөвт байгууллагын өөрийн орлого байна.



**1.2. Аймгийн ТЕЗ-ийн 2019 оны эхний хагас жилийн тайланд орлогын гүйцэтгэлийг үнэн зөв тайлагнаагүй байна.**

1.2.1. Аймгийн ТЕЗ-ийн 2019 оны татварын орлогын эхний хагас жилийн төлөвлөгөө 4103.1 сая төгрөг ба гүйцэтгэлээр 4399.8 сая төгрөгийн орлого төвлөрүүлж төлөвлөгөөг 107.2 хувиар биелүүлсэн боловч аймгийн ТЕЗ-ийн төсвийн гүйцэтгэлийн тайланд татварын орлогыг 392.2 сая төгрөгөөр дутуу тайлагнаж, аймгийн Татварын хэлтэс 218.8 сая төгрөгөөр илүү мэдээлжээ.

**“ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ”-Д ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН**

Хүснэгт 8. Татварын орлогын гүйцэтгэлийн судалгаа

сая.төг

Орлогын төрөл	Аудитаар			Э-тайлангаарх гүйцэтгэл	Татварын хэлтсийн мэдээгээр гүйцэтгэл	Зөрүү	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү			Э-тайлан	Татвар
<b>Татварын орлогын дүн</b>	<b>4103.1</b>	<b>4399.8</b>	<b>296.7</b>	<b>4007.7</b>	<b>4618.6</b>	<b>-392.2</b>	<b>218.8</b>
<b>1.Аймгийн нэгдсэн төсөв төсөв</b>	<b>2646.8</b>	<b>2797.2</b>	<b>150.4</b>	<b>2991.0</b>	<b>2784.7</b>	<b>193.8</b>	<b>-12.5</b>
а. ЦХТАО /суутган-1/	2363.0	2486.1	123.1	2495.7	2530.0	9.6	43.9
ХХОАТ-ын буцаан олголт	-400.0	-364.6	35.4	-364.6	-364.6	0.0	0.0
в. АТӨЯХАТ	426.0	401.8	-24.2	401.3	401.8	-0.5	0.0
г.Газрын төлбөр	133.0	176.1	43.1	362.4	116.5	186.3	-59.6
д. Үл хөдлөх хөрөнгийн татвар	124.8	97.8	-27.0	96.2	101.0	-1.6	3.2
<b>2. Орон нутгийн төсөв</b>	<b>1456.3</b>	<b>1602.6</b>	<b>146.3</b>	<b>1016.7</b>	<b>1833.9</b>	<b>-586.0</b>	<b>231.3</b>
<b>Хүн амын орлого</b>	<b>732.3</b>	<b>851.7</b>	<b>119.4</b>	<b>353.2</b>	<b>852.1</b>	<b>-498.5</b>	<b>0.4</b>
1. Үйл ажиллагааны орлого /ИОТТХ/	197.2	205.5	8.3	201.8	204.8	-3.7	-0.7
2. Үл хөдлөх хөрөнгө борлуулсны татвар	49.0	20.7	-28.3	0.3	20.6	-20.4	-0.1
3. Хөрөнгийн орлого /Хадгаламжийн хүү/	479.1	614.1	135.0	139.4	615.3	-474.7	1.2
4. Бууны татвар	7.0	11.4	4.4	11.7	11.4	0.3	0.0
<b>5. Бусад төлбөр хураамж</b>	<b>724.0</b>	<b>750.9</b>	<b>26.9</b>	<b>663.5</b>	<b>981.8</b>	<b>-87.5</b>	<b>230.9</b>
а.Улсын тэмдэгтийн хураамж	134.4	97.8	-36.6	127.7	120.7	29.9	22.9
б. Газрын дуудлага худалдааны орлого	50.0	186.4	136.4	0.1	248.9	-186.3	62.5
в. Орон нутгийн зам ашигласны төлбөр	160.0	104.5	-55.5	0.0	189.6	-104.5	85.1
г. Хог хаягдлын үйлчилгээний хураамж	253.3	187.3	-66.0	180.3	186.7	-7.0	-0.6
д.ус рашаан ашигласны төлбөр	120.0	30.0	-90.0	121.2	93.2	91.2	63.2
е..Түгээмэл тархацтай АМА Төлбөр	2.5	0.7	-1.8	1.8	0.8	1.1	0.1
ё.Ан, амьтан агнуурын нөөц ашигласны	0.0	76.2	76.2	76.2	76.2	0.0	0.0
ж.Нохойны татвар	3.8	4.1	0.3	3.9	3.7	-0.2	-0.4
з.Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр	0.0	62.0	62.0	62.0	62.0	0.0	0.0
и. Бусад татвар		1.8	1.8	90.3		88.5	-1.8

Дээрх хүснэгтээс харахад эхний хагас жилийн байдлаар 7 нэр төрлийн татварын орлогын төлөвлөгөө 1.8-90.0 сая төгрөгөөр тасарсан байна.

Аудитаар сумдын татварын орлогын гүйцэтгэлийг аймгийн Татварын хэлтсийн гаргаж ирүүлсэн 2019 оны эхний хагас жилийн татварын мэдээтэй тулган шалгахад Хүрээмарал, Гурванбулаг, Баянлиг сумаас бусад сумдын татварын байцаагч татварын орлогын гүйцэтгэлийг нийт 27.0 сая төгрөгөөр дутуу мэдээлсэн байна.

**Аудитын илрүүлэлт:**

- Эрдэнэцогт сум газрын дуудлага худалдааны орлогыг аймгийн дансанд төвлөрүүлсэн атлаа 400,0 мянган төгрөгөөр газрын татварыг илүү мэдээлсэн, ИОТТХ-аар 15.0 мянга, хадгаламжийн хүүгийн орлогыг 9.1 мянга, түгээмэл тархацтай ашигт малтмалын албан татварыг 20,0 мянган төгрөгөөр тус тус дутуу, хүү торгуулийн орлогыг 400,0 мянган төгрөгөөр илүү мэдээлсэн.
- Галуут сум ИОТТХ-ын орлогыг 60,1 мянга, хүү торгуулийн орлогыг 16,0 мянган төгрөгөөр дутуу, улсын тэмдэгтийн хураамжийг 10,0 мянган төгрөгөөр илүү мэдээлсэн.
- Жаргалант сумын Төрийн сангийн төлөөлөгч Улсын тэмдэгтийн хураамжийн 92,7 мянган төгрөгийг түгээмэл тархацтай АМАТ-т хааснаас татварын мэдээ зөрсөн. Хадгаламжийн хүүгийн орлогыг 1378,8 мянган төгрөгөөр илүү, ИОТТХ-ыг 521,8 мянган төгрөгөөр дутуу мэдээлсэн.
- Баян-Овоо сум цагдаагийн хүү торгуулийн орлогын 100,0 мянган төгрөгийг татварын мэдээнд мэдээлээгүй.
- Өлзийт сум нохойны татварын 161,0 мянган төгрөгийг хог хаягдлын хураамжид авч гүйцэтгэлийг нохойны татварт мэдээлээгүй. Улсын тэмдэгтийн хураамжийг 450,01 мянган төгрөгөөр дутуу мэдээлж, 1800,0 мянган төгрөгийн орлогыг татварын мэдээнд мэдээлээгүй;
- Бөмбөгөр сум газрын төлбөрийн 10,6 мянган төгрөгийг аймагт төвлөрүүлээгүй, орон нутгийн орлогод хааж, татварын орлогоор мэдээлээгүй.

- Баянбулаг сум хог хаягдлын хураамжийн 6 сарын орлогын 820,0 мянган төгрөгийг “Баянхонгор Эрчим хүч” ЦТХХК-аас шилжүүлсэн байхад татварын мэдээнд оруулж мэдээлээгүй.
- Заг сум газрын төлбөрийн 100031100943 тоот дансанд улсын тэмдэгтийн хураамж, нохойны татварыг авсан. ИОТТХ-ийн 912 дансанд хадгаламжийн хүүгийн орлогыг авсан бөгөөд ИОТТХ-ын орлогыг 124,1 мянган төгрөгөөр дутуу, хадгаламжийн хүүгийн орлогыг 486,7 мянган төгрөгөөр илүү, бууны татварыг 60,0 мянган төгрөгөөр илүү мэдээлсэн.
- Жинст сум хүү торгуулийн орлогыг 10,0 мянган төгрөгөөр илүү, хадгаламжийн хүүгийн орлогыг 5,5 мянга, улсын тэмдэгтийн хураамжийг 6,0 мянган төгрөгөөр дутуу мэдээлсэн.
- Богд сум хүү торгуулийн орлогыг 175 мянга, ИОТТХ-ийг 15,0 мянган төгрөгөөр дутуу, бууны татварыг 30,0 мянган төгрөгөөр илүү мэдээлсэн.
- Баянговь сум ИОТТХ-ыг 63,9 мянган төгрөгөөр илүү мэдээлсэн.
- Шинэжинст сум ИОТТХ-ыг 209.5 мянга, хадгаламжийн хүүгийн орлогыг 20.2 мянга, бууны татварыг 30.0 мянга, УТХураамжийг 55.0 мянга, хүү торгуулийн орлогыг 40.0 мянган төгрөгөөр дутуу мэдээлсэн байна.
- Баян-Өндөр сум ИОТТХ-ыг 814,6 мянга, бууны татварыг 90.0 мянга, нохойны татварыг 47.8 мянган төгрөгөөр дутуу, хадгаламжийн хүүгийн орлогыг 100.6 мянга, УТХураамжийг 25.0 мянга, хүү торгуулийн орлогыг 290.0 мянган төгрөгөөр илүү мэдээлсэн байна.
- Баянцагаан сум ИОТТХ-ыг 123.9 мянга, хадгаламжийн хүүгийн орлогыг 536.4 мянга, хүү торгуулийн орлогыг 82.3 мянган төгрөгөөр илүү, УТХ-ийг 6.0 мянган төгрөгөөр дутуу мэдээлсэн.
- Баацагаан сум хадгаламжийн хүүгийн орлогыг 692,6 мянга, УТХ-ыг 11.9 мянган төгрөгөөр илүү, ҮХЭХ борлуусаны орлогыг 80.0 мянга, нохойны татварыг 134.0 мянга, хүү торгуулийн орлогыг 1490.3 мянган төгрөгөөр дутуу мэдээлсэн.
- Бууцагаан сум газрын дуудлага худалдааны орлогыг аймгийн дансанд төвлөрүүлсэн атлаа 2560,8 мянган төгрөгөөр газрын татварыг илүү мэдээлсэн, ИОТТХ-ыг 380,1 мянган төгрөгөөр илүү мэдээлсэн.
- Баянхонгор сум ус, рашаан ашигласны төлбөрийн дансанд аймагт төвлөрөх 28035,0 мянган төгрөг андуурч орсныг Э-тайланд орлогоор бүртгэсэн байсныг аудитын явцад аймгийн төсөвт төвлөрүүлэв.
- Татварын орлогын гүйцэтгэлийг хуулгаар тулган шалгахад сумдын дүнгээр 6.8 сая төгрөгөөр татварын орлогыг санхүүгийн тайланд дутуу илэрхийлсэн байгаа нь сумдын албадын дарга нар орлогыг буруу мэдээлсэнтэй холбоотой байна.
- Хөрөнгийн орлогыг Баянцагаан, Бууцагаан, Гурванбулаг, Хүрээмарал, Шинэжинст сумдаас бусад сумд 506.8 сая төгрөгийн хөрөнгийн орлогыг санхүүгийн тайланд хүүгийн орлогоор мэдээлсэн зэрэг зөрчлүүд илэрсэн тул зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

Аймгийн татварын орлогын гүйцэтгэлийг төрийн сангийн дансны хуулгатай тулган шалгахад АТӨЯХАТ-аас бусад нэр төрлийн татварын орлогын гүйцэтгэлийг мэдээнээс зөрүүтэй гаргасан зөрчил илэрснийг тодруулахад сарын сүүлийн өдрүүдэд тушаасан орлого дансанд ороогүй байсан, татварын байцаагч орлогын мэргэжилтэн нар харилцах дансанд орсон орлогыг тооцоо нийлдэггүй тайланг гаргаж байгаатай холбоотой байна. Үүнд:

- Цалин хөлс түүнтэй адилтгах орлого татварын мэдээгээр 2530.0 сая төгрөг байхад дансны хуулгаар 2486.1 сая төгрөг буюу 43.9 сая төгрөгөөр зөрүүтэй байна. Энэ нь ЦХТАО-ийн дансанд 2019.07.01-нд орсон 45.5 сая төгрөгийн татварын эхний хагас жилийн орлогоор мэдээлж, татварын бүртгэлийн программын алдаанаас шалтгаалж давхардаж орсон, данс андуурснаас залруулагдсан 1.7 сая төгрөгийн татварыг хассантай холбоотой байна.
- Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын дансаар орсон орлогын дүн аймгийн Татварын хэлтсийн мэдээнээс 3.2 сая төгрөгөөр зөрүүтэй байгаа нь 3 татвар төлөгчийн 2019.06.27-2019.06.28-ний өдрүүдэд төлсөн 3.2 сая төгрөгийн татвар татварын Тайс программд тухайн өдөртөө хөрвөж орсон байхад хаалт нь ҮХЭХ-ийн албан татварын дансанд 2019.07.01-нд орсонтой холбоотой байна.

- Газрын төлбөр, газрын дуудлага худалдааны орлоготой хамт нэг дансанд төвлөрч байгаа ба татварын мэдээнээс дансны хуулгаар орлого 2.9 сая төгрөгөөр зөрүүтэй байгаа нь Бууцагаан сум 2.5 сая, Эрдэнэцогт сум 0.4 сая төгрөгийн дуудлага худалдааны орлогыг аймагт төвлөрүүлсэн атлаа сумын татварын мэдээнд орлогоор мэдээлснээс орлого давхардсан.
- Улсын тэмдэгтийн хураамж татварын мэдээгээр 85.8 сая төгрөг байхад дансны хуулгаар орлогын дүн 92.5 сая төгрөг буюу 6.7 сая төгрөгөөр зөрүүтэй байна. Энэ нь аймгийн СТХС-ийн орлогын мэргэжилтэн дансны хуулгыг өгөөгүйгээс 2019 оны 6 дугаар сарын 10003000941 тоот данснаас залруулагдсан 0.7 сая төгрөгийг хасаагүй, 10003000957 тоот дансанд 6 дугаар сард 7.4 сая төгрөгийн хураамжийн орлогыг төвлөрсөн байхад татварын хэлтэс мэдээндээ оруулаагүй байна.
- Орон нутгийн авто зам ашигласны хураамжийн орлогоор 104.5 сая төгрөг төвлөрсөн байхад аймгийн Татварын хэлтсийн мэдээнд 189.6 сая төгрөгөөр буюу 85.1 сая төгрөгөөр илүү мэдээлжээ.

Дээрх алдаанаас харахад аймгийн ЗДТГ-ын орлогын мэргэжилтэн, аймгийн Татварын хэлтсийн орлогын эдийн засагч нар ажлын харилцан уялдаагүй, мэдээг үнэн зөв гаргадаггүйтэй холбоотой бөгөөд тус алдаа өмнөх аудитаар илэрч зөвлөмж өгсөн байхад зөвлөмжийг холбогдох мэргэжилтнүүд хэрэгжүүлж ажиллаагүй байна. Иймд уг зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмжийг хүргүүлж, сумдын төсвийн төвлөрүүлэн захирагчдын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчлийг залруулаагүй, алдаа давтагдвал СТОУС-д заасан батламж мэдэгдлийг зөрчих тул дүгнэлтэд нөлөөлөхийг анхааруулж байна.

ХХОАТ-ын буцаан олголтод 2019 онд 800.0 сая төгрөг олгохоор батлагдсан боловч аймгийн Татварын хэлтсийн даргын 2019 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн А/22 тоот тушаалаар 1246 татвар төлөгчид 538.6 сая төгрөгийн албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэхээр баталж, үүнээс эхний хагас жилд 400.0 сая төгрөг олгохоор төлөвлөснөөс гүйцэтгэлээр 364.6 сая төгрөг олгожээ.

Баян-Өндөр, Баянцагаан, Баянговь сумын цагдаагийн хүү торгуулийн дансанд нийт 39.6 сая төгрөг данс андуурч орлого орсныг Баянцагаан сум санхүүгийн тайлан болон татварын мэдээнд орлогоор бүртгэсэн, харин Баян-Өндөр, Баянговь сум бүртгээгүй байгааг Сангийн яам, Татварын ерөнхий газарт асуудлыг тавьж шийдвэрлүүлэх зөвлөмжийг өгөв.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд аймгийн ТЕЗ-ийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг байршуулсан эсэхийг шалгахад 2019 оны 06 дугаар сарын мэдээг хугацаа хоцроож байршуулсан, 05 дугаар сарын мэдээг байршуулаагүй байгаа тул аудитын явцад 05 дугаар сарын мэдээг нөхөн байршуулж зөрчлийг арилгав.

Татварын Ерөнхий газар, Сангийн яамнаас сум бүрд татварын нэр төрлийн 14 дансыг 2017 онд нээж, татварын орлогыг тухайн дансанд төвлөрүүлэх ёстой байтал аудитаар сумууд орон нутгийн ерөнхий орлогын дансанд татварыг төвлөрүүлсэн,

татварыг өөр дансанд төвлөрүүлсэн зэрэг зөрчил илэрсэн тул залруулах зөвлөмжийг хүргүүлэв.

**Аудитын илрүүлэлт:**

- Гурванбулаг сум ИОТТХ-ийн дансанд хадгаламжийн хүүгийн орлогыг төвлөрүүлсэн;
- Заг сум ИОТТХ-ийн дансанд хадгаламжийн хүүгийн орлогыг, газрын төлбөрийн дансанд улсын тэмдэгтийн хураамж, нохойны албан татварыг төвлөрүүлсэн;
- Баянбулаг сум хоё хаягдлын хураамжийг сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлсэн;

1.2.2. Аймгийн ТЕЗ-ийн эхний хагас жилийн тайланд хүү торгуулийн орлогыг үнэн зөв тайлагнаагүй байна.

**Аудитын илрүүлэлт:**

Хяналт шалгалтын 5 байгууллагаас тогтоосон хүү торгуулийн орлогоор 2019 оны эхний хагас жилд 356.0 сая төгрөг төвлөрснөөс 9.3 сая төгрөгийн залруулга хийгдэж, 346.8 сая төгрөгийн орлого орсон байхад татварын мэдээгээр 353.1 сая төгрөгийг мэдээлж, орлого 6.3 сая төгрөгөөр зөрүүтэй байгаа нь Замын цагдаагийн газрын торгуулийн 1.2 сая, аймгийн ШШГГ-ын 4.9 сая төгрөгийн 2 удаагийн залруулгыг хасаагүйгээс татварын мэдээ, санхүүгийн тайлангийн орлого илүү мэдээлж, 0.2 сая төгрөгийн орлогыг зөрүүтэй мэдээлсэн байна. Иймд санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй андуурч орсон орлогыг залруулах албан шаардлагыг аймгийн СТСХ-т хүргүүлэв.

Сумд хүү торгуулийн орлогоор эхний хагас жилд 96.8 сая төгрөг оруулахаар төлөвлөсөн бөгөөд аудитаар дансны хуулгыг сум бүрээр тулган шалгахад 96.4 сая төгрөг оруулсан байхад аймгийн Татварын хэлтсийн мэдээнд 96.8 сая, аймгийн ТЕЗ-ийн 2019 оны эхний хагас жилийн тайланд 96.5 сая төгрөгөөр тайлагнаж, орлогыг үнэн зөв тайлагнаагүй байна.

1.2.3. ТБОНӨХ-д бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлогоор эхний хагас жилд 38.0 сая төгрөг оруулахаар төлөвлөснөөс 2019 оны эхний хагас жилд 3 суудлын автомашин, 2 үл хөдлөх хөрөнгө борлуулж, дуудлага худалдааны орлогоор 24.0 сая төгрөг оруулж, өмнөх оны дутуу 2.6 сая төгрөгийн орлогыг оруулж, төлөвлөгөө 11.4 сая төгрөгөөр тасарсан байна.

Дээрх орлого аймгийн ОНӨГ-ийн дансанд төвлөрсөн байхад орон нутгийн орлогод төвлөрүүлэлгүй, байгууллагын санхүүгийн тайланд 26.6 сая төгрөгийн орлогыг өөрийн орлогоор бүртгэсэн Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7.2, 23.12 дахь заалтыг зөрчсөн ба аудитын явцад тус орлогыг аймгийн төсөвт төвлөрүүлсэн болно.

1.2.4. Сумдын соёлын төв өөрийн орлогоор 9.2 сая төгрөг оруулахаар төлөвлөснөөс 2019 оны эхний хагас жилийн байдлаар 5.6 сая төгрөгийг 8 сумын соёлын төв байгууллагын үндсэн дансанд төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэлийн тайланд тайлагнасан, харин 11 сумын соёлын төв үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон 6.0 сая төгрөгийн байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлжээ.

Энэ нь Сангийн сайдын 2019 оны 74 тоот тушаалаар баталсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан

бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ын 3.4.3-т “үндсэн үйл ажиллагааны буюу байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх явцад бий болдог жил бүр давтагдах шинжтэй тогтмол орлогыг төсөвт тусгахгүй орхигдуулахыг хориглоно” гэж заасантай нийцэхгүй байгаа тул цаашид соёл урлагийн байгууллагуудын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болж байгаа орлогыг төсвийн бүрэлдэхүүн хэсэгт оруулж төлөвлөн, орлогыг байгууллагын үндсэн дансанд төвлөрүүлж, үндсэн үйл ажиллагааны орлогоор тайлагнаж байх нь зүйтэй байна.

**Аудитын илрүүлэлт**

- Баянговь сумын Соёлын төв үндсэн үйл ажиллагааны орлогоор 1.2 сая төгрөг орсныг санхүүгийн тайланд 2.2 сая төгрөгөөр буюу 1.0 сая төгрөгөөр илүү тайлагнасан;
- Баянговь сумын соёлын төвийн 1.7 сая төгрөгийн төлөвлөгөөг, Жаргалант сумын 0.7 сая төгрөгийн орлогын гүйцэтгэлийг туслах үйл ажиллагааны орлогоор тайлагнасан;
- Баян-Өндөр сумын Соёлын төв төсвөөс авсан 38.7 сая төгрөгийн санхүүжилтийг үндсэн үйл ажиллагааны орлогоор тайлагнасан тул залруулах албан шаардлага хүргүүлэв.
- Баян-Овоо, Эрдэнэцогт, Бөмбөгөр сумын Соёлын төвүүд үйл ажиллагааны орлогоор нэг ч төгрөг оруулаагүй байна.

Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн орлогоос 2019 оны эхний хагас жилд 10 сум 86 зээлдэгчдэд 709.5 сая төгрөгийн зээлийг олгожээ.

Аймгийн ХХААГ-т сум хөгжүүлэх сангийн орон тооны мэргэжилтэн ажилладаг бөгөөд, 2018 онд сум бүрд төсвийн хөрөнгөөр 750.0 мянган төгрөгийн үнэ бүхий сум хөгжүүлэх сангийн программ авсан байхад ашиглаагүй зөрчил илэрч аймгийн ТЕЗ-ийн 2018 оны санхүүгийн тайлангаар зөвлөмж хүргүүлсэн байхад арга хэмжээ аваагүй, программыг бүрэн ашиглаагүй байна.

Аймгийн ХХААГ-аас Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам, аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-т хүргүүлсэн сум хөгжүүлэх сангийн эхний хагас жилийн мэдээнд Баянхонгор сумын олгосон зээлийг 40.0 сая, Баян-Овоо сумын олгосон зээлийг 17.0 сая, Бууцагаан сумын олгосон зээлийг 6.0 сая, Бөмбөгөр сумын олгосон зээлийг 41.5 сая, Өлзийт сумын олгосон зээлийг 10.0 сая төгрөгөөр зөрүүтэй гаргаж хүргүүлсэн байна.

Иймд цаашид сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр авсан программыг ашиглаж, тайлан мэдээг үнэн зөв гаргаж байх албан шаардлагыг аймгийн ХХААГ-т хүргүүлэв.

Аудитын явцад Баянхонгор сумын СХС-гийн 2019 оны эхний хагас жилийн байдлаар хөрөнгийн зарцуулалт, зээлийн эргэн төлөлтийн байдалд аудит хийхээр төлөвлөсөн боловч хариуцсан мэргэжилтэн баримт материалыг ирүүлээгүйгээс аудит хийгдээгүй тул 2019 оны 10 сард багтаан холбогдох судалгаа, баримт материал ирүүлэх албан бичгийг Баянхонгор сумын Засаг даргад хүргүүлэв.

**Аудитын илрүүлэлт:**

Сум хөгжүүлэх сангийн орлогоор нийт 669.6 сая төгрөг орсон байхад санхүүгийн тайланд 9.2 сая төгрөгөөр илүү буюу 678.8 сая төгрөгөөр тусгасан байна. Энэ нь Баянбулаг

сум андуурч орсон 0.6 сая, Жинст сум залруулгын 5.0 сая, цалингийн суутганы 3.5 сая төгрөгийг сангийн орлогоор бүртгэсэн байгаа тул албан шаардлага хүргүүлэв.

Аймгийн ОНӨГ-аас ирүүлсэн Баянхонгор сумын ерөнхий боловсролын сургуулиудын түрээсийн орлогын судалгаанаас үзэхэд аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор баталсан түрээсийн төлбөрийн жишиг үнийг баримтлан түрээсийн гэрээг байгуулаагүй байгаа тул 2019-2020 оны хичээлийн жилээс эхлэн түрээсийн гэрээг дээрх журамд нийцүүлэн шинэчлэн байгуулж түрээсийн орлогыг дансанд бүрэн төвлөрүүлж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллах зөвлөмжийг аймгийн ОНӨГ-д хүргүүлэв. Мөн төсөвт байгууллагуудын түрээслэж байгаа хөрөнгө, түүнээс орох орлогын нэгдсэн судалгааг аймгийн хэмжээнд гаргаагүй байгаа тул аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар баталсан жишиг үнэээр тооцож, түрээсийн орлогын судалгааг 2019 оны 10 дугаар сарын 18-ны дотор гаргаж ирүүлэх албан шаардлагыг аймгийн ОНӨГ-т хүргүүлэв.

## БҮЛЭГ 2

ТЕЗ-ийн 2019 оны батлагдсан төсвийг зориулалтын дагуу, үр дүнтэй зарцуулж буй эсэх?

Бууцагаан сумын ЗДТГ-ын хуучин барилгыг төсвийн 129.0 сая төгрөгийн хөрөнгөөр худалдан авсан боловч холбогдох хууль тогтоомжийн дагуу бүртгээгүй, аймгийн Орон нутгийн өмчийн газар хяналт тавиагүйгээс орон нутгийн өмч хөрөнгө эзэнгүйдэх, үрэгдэх эрсдэл үүссэн байна.

**2.1. Аймгийн ТЕЗ-ийн 2019 оны төсвийн зарлагыг батлахдаа Сангийн яамнаас өгсөн “Орон нутгийн 2019 оны төсвийн төслийг боловсруулах, хэлэлцэн батлах, хэрэгжүүлэхэд баримтлах чиглэл, удирдамж”-ийг баримтлаагүй, Замын сангийн төсвийн зарлагыг санхүүжүүлэх эх үүсвэрээс 85.5 сая төгрөгөөр хэтрүүлэн, сумдын нийт зардлыг эх үүсвэрээсээ 243.4 сая төгрөгөөр дутуу баталсан байна.**

Аймаг, сумдын ИТХ-ын хуралдааны тогтоолоор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны зардлыг 78448.1 сая төгрөгөөр баталж, аймгийн ИТХ-ын хуралдааны 2019 оны 04 сарын 19-ны өдрийн 16/02 тоот тогтоолоор өмнөх оны үлдэгдлээс 715.1 сая төгрөгийг нэмж, нийт 79163.2 сая төгрөгөөр тодотгон баталсан байна.

Аймгийн ТЕЗ-ийн 2019 оны урсгал зардлыг өмнөх оноос 4504.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж 70553.2 сая, хөрөнгийн зардлыг 740.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж 8610.0 сая төгрөгөөр төлөвлөсөн байна. Төсвийн төлөвлөлтийн программд



хөрөнгийн зардлыг 7716.2 сая төгрөгөөр буюу 893.8 сая төгрөгөөр дутуу нь сумдын ОНХС-ийн зардлыг 39.0 сая төгрөгөөр дутуу оруулж, аймгийн Замын сангийн хөрөнгийн зардлыг Засгийн газрын дотоод шилжүүлгийн зардлын ангиллаар төлөвлөсөнтэй холбоотой байгаа тул зөрчлийг арилгах албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

2.1.1. Аймгийн ТЕЗ-ийн зарим зардлыг төлөвлөхдөө Сангийн яамнаас ирүүлсэн “Монгол улсын 2019 оны нэгдсэн төсвийн урсгал зардлын төсөл боловсруулахдаа цалин, тэтгэврийг инфляцийн өсөлттэй уялдуулж нэмэгдүүлэх, шатахуун, халаалт, гэрэл цахилгаан, интернет, шуудан холбоо, бичиг хэрэг, эд хогшил, урсгал засварын зардлыг 2018 оны түвшнээс нэмэгдүүлэхгүй байх, нэг удаагийн арга хэмжээний зардлыг бууруулах зарчмыг баримтлах чиглэл”-ийг баримтлаагүй нь дараах шалтгаантай байна.

**Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг** өмнөх оноос 1044.7 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн нь Эрдэнэцогт, Өлзийт сумын ЗДТГ, цэцэрлэг, Баян-Ойт цогцолбор сургуулийн барилга шинээр ашиглалтад орсон, Хүрээмарал, Гурванбулаг сумд төвлөрсөн халаалтад холбогдсонтой холбоотой байна.

**Хангамж, бараа материалын зардлыг** 2019 онд орон нутгийн төсвийн суурь зардлыг тухайн орон нутгийн алслалт, хүн ам, малын тоо толгой, газар нутгийн хэмжээ, газар зүйн онцлог, дэд бүтцийн хөгжил, тухайн бүс нутаг дахь бараа үйлчилгээний зах зээлийн үнэ ханш зэрэг орон нутгийн онцлог, хэрэгцээнд тохирсон байдлаар төсөвт байгууллагуудын тээвэр шатахуун, бичиг хэрэг, шуудан холбоо зэрэг зардлын хэмжээг тооцоход тус зардал 2018 оны түвшнээс 453,8 сая төгрөгөөр нэмэгджээ.

**Нормативт зардал:** Норматив зардлыг нийт 314.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөсөн байна. Үүнээс эм, бэлдмэлийн зардлыг 49.6 сая, хоол, хүнсний зардлыг 304.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж, нормын хувцас, зөөлөн эдлэлийн зардлыг 39.4 сая төгрөгөөр бууруулсан байна.

Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн зардлыг 40 байгууллага 48.1 сая төгрөгөөр өссөн нь хэвтэн эмчлүүлэгчдийн тоо нэмэгдүүлж, хоол хүнсний зардлыг 304.5 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн нь Баянхонгор сумын 5 дугаар сургууль, 16 дугаар цэцэрлэгийг 2019 онд ашиглалтанд оруулахаар тооцож хүүхдийн тоог өмнөх оноос 738-аар нэмэгдүүлж төлөвлөсөнтэй холбоотой байна.

**Эд хогшил, урсгал засварын зардлыг** өмнөх оноос 902.6 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн нь 115 байгууллагын урсгал засварын зардлыг 545.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж, зарим төсөвт байгууллагуудын барилга шинээр баригдсантай

холбоотой эд хогшил худалдан авсан, сумдын ЭМТ-үүдэд 1.4 сая, сургуулиудад 10.0 сая төгрөгөөр эд хогшил худалдан авахаар авч өгөхөөр төлөвлөсөнтэй холбоотой байна.

**Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний телбэр, хураамж:** Өмнөх оноос тус зардлыг 4735.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөсөн нь сумдын СХС-ийн зардлыг өмнө нь Засгийн газрын дотоод шилжүүлэг, бараа үйлчилгээний бусад зардал гэсэн эдийн засгийн ангиллаар бүртгэж, тайлагнаж байсныг өөрчилж, 2019 онд бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний телбэр, хураамжийн зардлаар бүртгэж, СХС-ийн 2988.8 сая төгрөгийн зардлаас 2641.6 сая, аймгийн ОНХС-аас санхүүжих мал эмнэлгийн үйлчилгээний хөлс 517.5 сая, шинээр ашиглалтад орох 5 дугаар сургуулийн урсгал зардлыг 1617.3 сая төгрөгийг ерөнхий боловсролын сургуулийн ерөнхий дансанд зардлыг ангилж төлөвлөсөнтэй холбоотой байна.

**Бараа үйлчилгээний бусад зардал:** Бараа үйлчилгээний бусад зардлыг өмнөх оноос 210.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөсөн нь ангилагдаагүй зардлаас санхүүжих төсөл, арга хэмжээ өмнөх оноос 851.2 сая төгрөгөөр нэмэгдэж зарим сумдын СХС-ийн зардлыг өмнөх онд тус зардалд төлөвлөж тайлагнаж байсантай холбоотой байна.

Ангилагдаагүй зардлын хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл арга хэмжээг аймгийн ИТХ-ын 2018 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 14/03 тоот тогтоолоор 1756.9 сая төгрөгөөр анх баталж 2019 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 16/02 тоот тогтоолоор орон нутгийн төсвийн урьд оны үлдэгдлээс 355.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэн нийт 2112.5 сая төгрөгөөр тодотгон баталсан ба Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1<sup>6</sup> -т заасан зарчмыг хэрэгжүүлээгүйгээс 157.0 сая төгрөгийн төсвийн хөрөнгийн үр ашиг гараагүй байна.

**Аудитын илрүүлэлт:**

• Нарийн сортын өвлийн хүлэмж барьж, байгуулах ажилд 157.0 сая төгрөг төлөвлөж тус арга хэмжээг хэрэгжүүлэх орон нутгийн өмчит “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-д 2019 оны 05 дугаар сард 157.0 сая төгрөг шилжүүлсэн ч 2019 оны 09 дүгээр сард ангилагдаагүй зардлын дансанд буцаан татсан байна. Энэ талаар “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК нь энэхүү төслийг “Өвдгийн шанд” ГҮТББ хэрэгжүүлж манайх хяналт тавих үүрэгтэй байсан боловч худалдан авах ажиллагаа нь хуульд нийцэхгүй, мөн аймгийн СТСХ-ээс санхүүжилтийг буцаан шилжүүл гэсний дагуу буцаан шилжүүлсэн” гэсэн тайлбарыг өгч байгаа цаашид төсөл, арга хэмжээг эдийн засгийн тооцоо, судалгаа, хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлж төсвийн төлөвлөлт, хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

<sup>6</sup> төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;

**Засгийн газрын дотоод шилжүүлгийн зардал:** Засгийн газрын дотоод шилжүүлгийг өмнөх оноос 1647.5 сая төгрөгөөр бууруулж төлөвлөсөн нь аймаг сумдын орон нутгийн хөрөнгө оруулалтын зардлыг тус онд батлаагүйтэй холбоотой.

Замын сангийн хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээ өмнөх оноос 341.2 сая төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд төсөл арга хэмжээг аймгийн ИТХ-ын 2018 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 14/03 тоот тогтоолоор 706.1 сая төгрөгөөр анх баталж 2019 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 16/02 тоот тогтоолоор 198.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэн нийт 904.7 сая төгрөгөөр баталсан байна.

Санхүүжүүлэх эх үүсвэрийг авто зам ашигласны хураамжийн орлогоос 194.6 сая, АТБӨЯХА татварын орлогоос 426.0 сая замын сангийн урьд оны үлдэгдлээс 284.4 сая төгрөгөөр тус тус баталжээ.

Аймгийн автозамын сангийн хөрөнгөөр 2019 онд өмнөх оноос шилжих 4 төсөл, арга хэмжээнд 180.2 сая, 2019 онд шинээр хэрэгжүүлэх 11 төсөл, арга хэмжээнд 664.3 сая, албан журмын даатгагчдын холбоонд 49.7 сая, автозамын тухай хуулийн 24.5-д заасан хяналтын зардалд 10.5 сая төгрөг олгохоор тус тус төлөвлөжээ.

**Аудитын илрүүлэлт:**

*Замын сангийн 2018 оны харилцах дансны үлдэгдэл нь 198.6 сая төгрөг байхад урьд оны үлдэгдлээс санхүүжих эх үүсвэрийг аймгийн ИТХ-ын хуралдааны 2018 оны 14/03 тоот тогтоолоор 284.1 сая төгрөгөөр баталж 85.5 сая төгрөгийн алдагдалтай төсөв баталсан нь Төсвийн тухай хуулийн 57.2<sup>7</sup>, 57.3<sup>8</sup> дахь заалтуудыг тус тус зөрчсөн бөгөөд Сангийн яамны төсвийн төлөвлөлтийг программд тус алдагдлыг төсөвт байгууллагын өөрийн орлогоор санхүүжихээр оруулсан зөрчилтэй байхад аймгийн СТХС-ийн үйл ажиллагаанд тавих хяналт хангалтгүй байгааг харуулж байна.*

*Улмаар төлөвлөсөн төсөл арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл үүсэж байгаа тул тус зөрчлийг арилгах албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэв*

**Бусад урсгал шилжүүлгийн зардал:** Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг улсын төсвөөс шууд олгохоор шилжүүлсэн, боловсролын салбарын тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэгийг аймгийн БСУГ-аар дамжуулж олгохоор шийдвэрлэсэн зэргээс шалтгаалж өмнөх оноос 8852,6 сая төгрөгөөр тус зардал буурсан байна.

Аймаг, сумдын ИТХ-аар баталсан төсөвт байгууллагуулын 2019 оны төсвийн зардлыг Сангийн яамны төсвийн төлөвлөлтийн программд оруулсан төсөвтэй тулган шалгахад 32 байгууллагын төсвийг 187.9 сая төгрөгөөр зөрүүтэй оруулсныг төсвийн мэргэжилтнүүдээс тодруулахад тайлбар ирүүлээгүй бөгөөд энэ нь ажлын хариуцлагатай шууд холбоотой байна. /Хавсралт судалгаа №11/

<sup>7</sup> 57.2.Орон нутгийн төсвийг алдагдалгүй төлөвлөн баталж, хэрэгжүүлнэ.

<sup>8</sup> 57.3.Орон нутгийн төсвийн урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх зарлагыг төсөвт тусган баталж хэрэгжүүлэх ба зарлага нь санхүүжүүлэх эх үүсвэрээсээ хэтрэхгүй байна.

2.1.2. Хөрөнгийн зардлыг өмнөх оноос 740.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж 8610.0 сая төгрөгөөр төлөвлөсөн нь аймаг, сумдын Орон нутгийн хөгжлийн сан, Замын сангийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлэх 312 төсөл арга хэмжээний зардал баталсан байна.



2.2. Аймгийн ТЕЗ-ийн эхний хагас жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланд зардлыг батлагдсан хөтөлбөр, арга хэмжээний дагуу үнэн зөв тайлагнаагүй байна.

2.2.1 Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны төсвийн гүйцэтгэлийн эхний хагас жилийн байдлаар 47155.6 сая төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 41445.9 сая төгрөгөөр зарцуулж, батлагдсан төсвийг 5709.7 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Хүснэгт 9. Зардлын гүйцэтгэлийн судалгаа

сая.төг

Үзүүлэлт	2019 оны эхний хагас жилийн байдлаар		
	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	21,253.34	20,369.53	-883.81
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,708.81	2,593.59	-115.22
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,440.48	4,103.50	-336.98
Хангамж, бараа материалын зардал	981.11	806.41	-174.69
Нормативт зардал	1,945.18	1,381.27	-563.91
Эд хогшил, урсгал засварын зардал	1,055.33	740.72	-314.61
Томилолт, зочны зардал	344.15	265.14	-79.01
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,045.75	2,685.85	-1,359.90
Бараа үйлчилгээний бусад зардал	3,601.23	2,430.05	-1,171.18
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	295.45	468.13	172.68
Засгийн газрын дотоод шилжүүлэг	727.42	144.42	-583.01
Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	-	0.64	0.64
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	167.86	168.36	0.5
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	39.57	37.53	-2.04
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	492.88	330.72	-162.16
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	159.06	152.27	-6.79
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	281.14	120.52	-160.62
<b>УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>42,538.75</b>	<b>36,798.63</b>	<b>-5,740.11</b>
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>4,616.89</b>	<b>4,647.29</b>	<b>30.4</b>
<b>НИЙТ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>47,155.64</b>	<b>41,445.92</b>	<b>-5,709.72</b>

Аудитаар төсөвт байгууллагын зардлын гүйцэтгэлийг тулган шалгахад Э-тайланд ажиллагсдын тоог зөрүүтэй оруулсан, төсвийн гүйцэтгэлээс мэдээнээс

зардлыг зөрүүтэй тайлагнасан, зардлыг Шилэн дансны цахим хуудсанд үнэн зөв мэдээлээгүй зэрэг зөрчлүүд илэрч байгаа нь Сангийн яам ТЕЗ-дын хагас жилийн тайланг хянаж хүлээж авдаггүйтэй холбоотой байна.

**Аудитын илрүүлэлт:**

**Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой:** Баянговь сумын ЗДТГ, ИТХ, Сургууль, Соёлын төв, ЭМТ, Жаргалант сумын ИТХ, Соёлын төв, Шинэжинст сумын ЗДТГ, ИТХ, аймгийн Ахмад настны асрамжийн төв, Галуут сумын Соёлын төв, Эрдэнэцогт сумын сургуулиуд шилэн дансанд мэдээлэл байршуулаагүй, Галуут сумын ЗДТГ, ИТХ, ЕБС, Мандалын бага сургууль, цэцэрлэг, ЭМТ, Эрдэнэцогт сумын ЗДТГ, ИТХ шилэн дансанд мэдээллийг 29.2 сая төгрөгөөр зөрүүтэй тусгасан.

**2019 оны эхний хагас жилийн зардлын гүйцэтгэлтэй холбоотой:**

**Цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг** батлагдсан төсвийн хүрээнд зарцуулсан боловч, 22 байгууллагын төсвийн гүйцэтгэлийн тайлан нь төсвийн гүйцэтгэлийн мэдээнээс 16.7 сая төгрөгөөр зөрүүтэй, цалингийн зардал, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаар зөрүүтэй тайлагнасан байна.

**Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг** батлагдсан төсвийн хүрээнд зарцуулсан боловч Орон нутгийн музей 635,9 мянга, Жинст сумын Цэцэрлэг 218,1 мянган төгрөгөөр тус тус дутуу, Бууцагаан сумын ЗДТГ 151,3 мянган төгрөгөөр илүү тайлагнаж, тайланг зөрүүтэй гаргасан байна.

**Тогтмол зардлыг** Жинст сумын Цэцэрлэг 176,2 мянга, Жаргалант сумын Цэцэрлэг 2327,8 мянган төгрөгөөр төсвийн гүйцэтгэлийн мэдээнээс тус тус илүү тайлагнасан байна.

**Нормативт зардлыг** төсвийн гүйцэтгэлийн мэдээнээс Баянговь сумын ЭМТ 7386,0 мянга, 13-р цэцэрлэг 34,6 мянга, Богд сумын Цэцэрлэг 1498,0 мянган төгрөгөөр тус тус илүү, Жинст сумын Цэцэрлэг 450,7 мянган төгрөгөөр дутуу илирхийлжээ.

Мөн Номун далай сургууль хүүхдийн хоолны зардал 34149,6 мянган төгрөгийг эм бэлдмэлийн зардалд, эм бэлдмэлийн зардал 1050,0 мянган төгрөгийг хүүхдийн хоолны зардлаар, Жинст сумын ЭМТ хоолны зардал, нормын хувцас зөөлөн эдлэлийн зардлыг 651,7 мянган төгрөгөөр зөрүүлж тайланд тусгасан байна.

**Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг** эхний хагас жилийн тайланд төсвийн гүйцэтгэлийн мэдээнээс зөрүүтэй илэрхийлсэн байна. Тухайлбал: Хөрөнгийн зардлаар бүртгэх аймгийн ОНХС-гийн 713901,5 мянган төгрөгийн зарлагыг энэ зардлын /БГБНАУТ хураамж/ нэрээр бүртгэсэн, энэ зардлаар төсөв батлагдаагүй, зарцуулалтын эрх нээгдээгүй байхад Баацагаан сумын ЭМТ 510,0 мянга, аймгийн Орон нутгийн музей 33,0 мянга, Бууцагаан сумын ИТХ 500,0 мянга, Жинст сумын сургууль 276,4 мянган төгрөгийн зарлага гаргаж, санхүүгийн тайланд буруу илэрхийлсэн.

Мөн энэ зардлыг төсвийн гүйцэтгэлийн мэдээнээс дараах байгууллагууд зөрүүтэйгээр санхүүгийн тайланд тусгажээ. Номундалай сургууль 4098,3 мянга, Бууцагаан сумын ЗДТГ 5330,8 мянга, Богд сумын ЗДТГ 597,0 мянга, Баацагаан сумын СХС 2000,0 мянга, Жинст сумын СХС 13947,0 мянган төгрөгөөр тус тус илүү тайлагнасан байна.

**Бараа үйлчилгээний бусад зардлын тайланд** Баянбулаг сумын ЭМТ 848,0 мянга, Баянговь сумын Цэцэрлэг 4637,1 мянга, аймгийн Хот тохижилт үйлчилгээний газар 364,7 мянга, 3-р цэцэрлэг 432,0 мянга, 4-р цэцэрлэг 714,8 мянга, Бөмбөгөр сумын ИТХ 1750,0 мянга, Галуут сумын ЕБС 340,2 мянга, Мандалын бага сургууль 110,0 мянга, Гурванбулаг сумын ЗДТГ 198,0 мянга, Жаргалант сумын ИТХ 290,5 мянга, Жинст сумын ЗДТГ 1153,0 мянга, Жинст сумын Цэцэрлэг 218,1 мянга, Шинэжинст сумын ЭМТ 1500,0 мянган төгрөгөөр төсвийн гүйцэтгэлийн мэдээнээс тус тус зөрүүлж санхүүгийн тайланд тусгасан байна.

**Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж:** Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардалд эхний хагас жилд төсвийн хуваарийн дагуу 135511,2 мянган төгрөг батлагдсан байхад 152269,1 мянган төгрөг олгосон байна. Үүнд Шинэжинст сумын ЗДТГ 8045,9 мянга, Эрдэнэцогт сумын Сургууль 8711,9 мянган төгрөгийн тэтгэмжийг илүү олгожээ. Энэ нь төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшууллын зардал, ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулалын зардлыг тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардлаар тайлагнасантай холбоотой байна.

**Замын сан**

Замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд 2019 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр төсөл, арга хэмжээнд 180.6 сая төгрөг

Төсөл, арга хэмжээ	Төлөвлөсөн		Эхний хагас жилийн гүйцэтгэл	
	тоо	дүн	тоо	дүн
	Шилжих хөрөнгө оруулалт	4	180.2	1
Шинээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт	11	664.3	3	135.8
Албан журмын даатгагчдын холбоонд	-	49.7	-	37.7
Хяналтын зардал	-	10.5	-	-
<b>Дүн</b>	<b>15</b>	<b>904.7</b>	<b>4.00</b>	<b>180.6</b>

зарцуулснаас 4 төсөл арга хэмжээний урьдчилгаа санхүүжилтэд 141.8 сая төгрөгийг олгосон байна.

**Ангилалдаагүй зардал**

Ангилалдаагүй зардлын хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл арга хэмжээг аймгийн ИТХ-ын 2018 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 14/03 тоот тогтоолоор 1756.9 сая төгрөгөөр анх баталж 2019 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 16/02 тоот тогтоолоор орон нутгийн төсвийн урьд оны үлдэгдлээс 355.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэн нийт 2112.5 сая төгрөгөөр тодотгон баталж эхний хагас жилийн байдлаар 1183.1 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.



**Аудитын илрүүлэлт:**

- Ламын гэгээнтний түүхэн кино бүтээх 50.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий арга хэмжээг хэрэгжүүлэхдээ “Ламын гэгээний гон гандан дэдлин хийд”, “Лайтзүүм” ХХК-тай 2018.08.26-д байгуулсан 50.0 сая төгрөгийн өртөг бүхий хамтран ажиллах гэрээний дагуу “Лайтзүүм” ХХК –д 24.0 сая, “Ламын гэгээний гон гандан дэдлин хийд”-ийн дансанд 26.0 сая төгрөг шилжүүлсэн байна. “Ламын гэгээний гон гандан дэдлин хийд” нь тус 26.0 сая төгрөгийг гэрээнд заасан гүйцэтгэгч компанийн дансанд бус компанийн захирал Б.Тогтохдэмбэрэлийн хувийн харилцах дансанд шилжүүлсэн байна. Энэ нь “Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнэ”-ийг мөрдөөгүй шууд гэрээ байгуулан худалдан авсан байна. Тус киног хүлээж авч хөрөнгөнд бүртгээгүй байсныг аудитын явцад аймгийн Төрийн архивын газарт хүлээлгэн өгч бүртгүүлсэн болно. Цаашид ТБОНӨХБАУХАТХ-ийн 5.1.15<sup>9</sup>-д заасан зөвлөх үйлчилгээний ажлыг хэрэгжүүлэхдээ хуулийн 4 дүгээр бүлэгт заасныг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлж тус киног хөрөнгөд бүртгэх албан шаардлагыг аймгийн ЗДТГ-д хүргүүлэв.
- Бууцагаан сумын хуучин ЗДТГ-ын барилгыг худалдаж авах арга хэмжээнд ангилалдаагүй зардлаас 129.0 сая төгрөг баталж зарцуулсан байна. Тус барилгыг аймгийн ИТХ-ын

<sup>9</sup> “зөвлөх үйлчилгээ” гэж гүйцэтгэгчээс төсөл зохиох, хэрэгжүүлэх, сургалт явуулах, техникийн туслалцаа үзүүлэх, түүнчлэн судалгаа шинжилгээ хийх, зураг төсөл боловсруулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих тусгай мэдлэг, ур чадварын үндсэн дээр үзүүлж байгаа мэргэжлийн үйлчилгээг;

Тэргүүлэгчдийн 2015 оны 34 дүгээр тогтоолоор худалдах шийдвэр анх гарч, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 10 дугаар тогтоолоор худалдах доод үнийг 20 хувиар бууруулснаар Бууцагаан сумын иргэн Ц.Лхагвасүрэнтэй “Үл хөдлөх хөрөнгө зээлээр худалдах, худалдан авах гэрээ” байгуулан 78.0 сая төгрөгөөр худалджээ. Иргэн Ц.Лхагвасүрэн нь тус барилгын үнийг гэрээний дагуу 2016 оны 10 дугаар сард бүрэн төлж дуусгахаар байсан ч 2017 оны 12 дугаар сарын 19-ний өдөр төлж дуусгасан байна.

1. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 36 дугаар тогтоолоор дээрх 2016 оны 10 дугаар тогтоолыг хүчингүй болгож барилгыг худалдан авсан иргэнд нөхөн олговор олгох шийдвэр гарчээ. Мөн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 54 дүгээр тогтоолоор тус барилгын 576.7 м<sup>2</sup> талбай бүхий хэсгийг Онцгой байдлын ерөнхий газарт балансаас балансад шилжүүлж 496.3м<sup>2</sup> талбай бүхий хэсгийг орон нутгийн өмчид хэвээр үлдээх шийдвэр гаргасан байтлаа аймгийн ИТХ-ын хуралдааны 2018 оны 14/03 тоот тогтоолоор аймгийн 2019 оны төсөвт тус барилгыг Онцгой байдлын газарт худалдан авч өгөхөөр 129.0 сая төгрөг баталж өгсөн нь аймгийн ИТХ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.2<sup>10</sup> -т заасан бүрэн эрхээ хэрэгжүүлж ажиллахгүй байгаагаас төсвөөс 51.0 сая төгрөгийн илүү зардал гарсан байна.

2. Аймгийн Засаг даргын 2019 оны А/202 тоот захирамжаар иргэн Ц.Лхагвасүрэнгээс тус барилгыг 129.0 сая төгрөгөөр худалдан авч Онцгой байдлын ерөнхий газарт шилжүүлэх шийдвэр гаргасны дагуу аймгийн Онцгой байдлын газар, иргэн Ц.Лхагвасүрэнтэй байгуулсан худалдах худалдан авах гэрээг үндэслэн 129.0 сая төгрөгийг 2019 оны 04 дүгээр сарын 08-д иргэн Ц.Лхагвасүрэнд шилжүүлсэн байна. Гэвч тус барилга нь бүхэлдээ төрийн болон орон нутгийн өмчийн аль алинд бүртгэлгүй, тус барилгын болон газар эзэмших эрхийн гэрчилгээ нь иргэн Ц.Лхагвасүрэнгийн нэр дээр бүртгэлтэй гэрчилгээнүүдийн эх хувийг нь мөн тус иргэнээс аваагүй нь төсвийн хөрөнгөнд тавих хяналт суларч, хөрөнгө үрээдэх нөхцөл байдал үүссэн байна. Иймд тус барилгыг орон нутгийн өмчид бүртгэж бичиг баримтыг хуулийн дагуу шилжүүлэн авч хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг холбогдох хууль журмын хүрээнд явуулах албан шаардлагыг аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүргүүлэв.

2.2.2. Аймаг, сумдын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2019 онд 7755.1 сая төгрөгийн 301 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс эхний хагас жилийн гүйцэтгэлээр 1776.8 сая төгрөгийн 116 төсөл, арга хэмжээг санхүүжүүлсэн байна.

#### **Аудитын илрүүлэлт:**

- Аймгийн ОНХС-ийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн 713.9 сая төгрөгийн зардлыг бараа үйлчилгээний бусад зардлаар эдийн засгийн ангиллыг зөрүүтэй тайлагнасан тул залруулах албан шаардлагыг хүргүүлэв.
- Улсын төсвийн эрх шилжсэн хөрөнгө оруулалтын санхүүжилт 3584.3 сая төгрөгийн зардлыг төсвийн гүйцэтгэлийн тайланд хөрөнгийн зардлаар тайлагнасныг аудитын явцад залруулсан болно.

#### **БҮЛЭГ 3**

**Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан эсэх?**

**Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүйгээс зөрчил дутагдал давтагдаж гарсаар байна.**

3.1.1. Аймгийн ТЕЗ-ийн 2018 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар аймгийн Засаг дарга, аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн дарга нарт 6 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлсэн боловч Сангийн сайдын 2015 оны 90 дүгээр тушаалаар

<sup>10</sup> иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, Засаг даргаас орон нутгийн өмчийн хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ хэрэгжүүлэх талаар зохиосон ажил, үр ашгийн тайлан, нэгдсэн тооллогын дүнг жил бүр хэлэлцэж, дүгнэлт, чиглэл өгөх;

баталсан “Орон нутгийн санхүү, төрийн сангийн ажилтны ажил үүргийн жишиг заавар”-ын 1.5.3-д “Дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн нь хяналтын байгууллагаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг удирдлагаар батлуулж, хэрэгжилтийг хангуулах, биелэлтийн нэгдсэн дүн, тайланг холбогдох байгууллагуудад хүргүүлэх” гэж заасныг хэрэгжүүлж төлөвлөгөө гаргаж ажиллаагүй байна.

3.1.2. Аудитаар өгсөн зөвлөмжийн мөрөөр зохиосон ажил, түүний хэрэгжилт үр дүнг 2019 оны 08 дугаар сарын 01-ний дотор ирүүлэх хугацаатай байхад зөвлөмжийн хариуг хугацаа хоцроож 2019 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр 5/1092 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2019 оны 09 дүгээр сарын 13-ний байдлаар шалгахад 2 зөвлөмжийг бүрэн, 1 зөвлөмжийг дутуу хэрэгжүүлж, 3 зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс зөвлөмжийн биелэлт дунджаар 41.7 хувьтай дүгнэсэн байна.

Аймгийн ТЕЗ-ийн 2019 оны хагас жилийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5 заасан бүрэлдэхүүн тус бүрээр гаргаж ирүүлээгүй, төсвийн гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж ажилласан гэх боловч цаасаар баталгаажуулсан баримтыг ирүүлээгүй, сумдын ИТХ-аар баталсан тогтоолыг хянаж, төсөвт байгууллагын орон тоо, татварын орлогын төлөвлөгөөг тухай бүр төсвийн төлөвлөлтийн программд үнэн зөв оруулаагүй, төсвийн гүйцэтгэлийн тайлангийн татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл, аймгийн Татварын хэлтсийн мэдээнээс зөрүүтэй тайлагнадаг зөрчил арилаагүй, аймгийн ТЕЗ-ийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний тоон болон чанарын үзүүлэлтийн биелэлтэд дотоод аудит хийж, үр дүнг тооцож ажиллаагүй байна.

Аудитаар нийт 2363.6 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлснээс 1961.2 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгч, 402.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад хүргүүлэв.

Төсвийн тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн тус аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг залруулаагүй, 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дээрх алдаанууд давтагдан гарч Санхүүгийн тайлангийн Олон улсын стандартад заасан санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийг зөрчих тул аймгийн ТЕЗ-ийн дүгнэлтэд нөлөөлөх тул анхаарч ажиллана уу.

## АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. Сангийн яамнаас өгсөн “Орон нутгийн 2019 оны төсвийн төслийг боловсруулах, хэлэлцэн батлах, хэрэгжүүлэхэд баримтлах чиглэл, удирдамж”-ийн дагуу орлого, зарлагын тооцоолол, судалгаа хийхгүйгээр төсвийн төлөвлөлтийг өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн төлөвлөдөг байдал хэвээр үргэлжилсээр байна.
2. Аймгийн ИТХ 85.5 сая, сумдын ИТХ 243.4 сая төгрөгөөр 2019 оны төсвийн зарлагыг санхүүжүүлэх эх үүсвэрээс нь зөрүүтэй баталж, Төсвийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2 дахь заалтыг зөрчсөн байна.
3. Аймгийн СТХС-ийн мэргэжилтнүүд Сангийн яамны төсвийн төлөвлөлтийн программд аймаг, сумдын ИТХ-ын хуралдааны тогтоолоор батлагдсан төсвийн нийт эх үүсвэрийн төлөвлөгөөг 29.9 сая, төсвийн зарлагын төлөвлөгөөг 187.9 сая төгрөгөөр зөрүүтэй оруулсан байна.
4. Ламын гэгээнтний түүхэн кино бүтээх ажлыг 50.0 сая төгрөгөөр хэрэгжүүлэхдээ ТБОНӨХБАҮХАТ хуулийн 4 дүгээр бүлэгт заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.
5. Сумдын татварын байцаагч нар сумын татварын орлогын нэр төрөл, гүйцэтгэлийг үнэн зөв мэдээлээгүйгээс Татварын хэлтсийн мэдээ бодит гүйцэтгэлээс 218.8 сая төгрөгөөр илүү мэдээлэгдсэн байна.
6. Төсөвт байгууллагын нягтлан бодогч нар батлагдсан хөтөлбөр, арга хэмжээний дагуу төсвийн орлого, зардлын гүйцэтгэлийг Э-тайланд үнэн зөв тайлагнаагүйгээс аймгийн ТЕЗ-ийн 2019 оны эхний хагас жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлан зөрүүтэй илэрхийлэгдсэн нь түүнд тавих шат шатны хяналт хангалтгүй байгаатай холбоотой байна.
7. Төсвийн 129.0 сая төгрөгийн хөрөнгөөр худалдан авсан Бууцагаан сумын ЗДТГ-ын хуучин барилгыг холбогдох хууль тогтоомжийн дагуу бүртгээгүй, аймгийн Орон нутгийн өмчийн газар хяналт тавиагүйгээс орон нутгийн өмч хөрөнгө эзэнгүйдэх, үрэгдэх эрсдэл үүссэн байна.
8. Аймгийн ХХААГ-ын сум хөгжүүлэх сан хариуцсан мэргэжилтний ажлын хариуцлагагүйгээс 2019 оны эхний хагас жилийн сум хөгжүүлэх сангийн нэгдсэн мэдээг Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам, аймгийн Засаг даргад үнэн зөв мэдээлээгүй ба сумдын сум хөгжүүлэх сангийн 13.5 сая төгрөгийн хөрөнгөөр 2018-2019 онд худалдан авсан сангийн бүртгэлийн программыг ашиглаж мэдээ тайланг гаргахгүй байгаагаас төсвийн хөрөнгийн үр ашиг гараагүй байна.

9. Аймгийн ОНӨГ нь аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 43 тоот тогтоолоор баталсан түрээсийн төлбөрийн жишиг үнийг баримталж, төсөвт байгууллагуудтай түрээсийн гэрээ байгуулаагүй, түрээсийн орлогын гүйцэтгэлд хяналт тавиагүй, орон нутгийн өмч хөрөнгийг түрээслүүлсэн талаар нэгдсэн судалгаа байхгүй, төрийн болон орон нутгийн өмч хөрөнгө борлуулсны орлогыг тухай бүр орон нутгийн төсөвт төвлөрүүлээгүй байна.
10. Аймгийн ТЕЗ-ийн 2018 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу төлөвлөгөө гаргаагүй, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүйгээс өмнөх аудитаар гарсан зөрчлүүд давтагдан гарсаар байна.

## **АУДИТЫН ЗӨВЛӨМЖ**

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурьдсан албан тушаалтнуудад зөвлөж байна.

### **Нэг. Аймгийн ИТХ-ын дарга Ц.Отгонбаяр танаа**

1. Орон нутгийн өмчийн барилга байгууламжийг актлах, худалдах шийдвэр гаргахдаа хөрөнгийн хэрэгцээ шаардлага, төрийн байгууллагын үйл ажиллагаанд цаашид ашиглах боломжтой эсэхийг тооцож байх.
2. Худалдан борлуулсан хуучин барилга байгууламжийг төсвийн хөрөнгөөр өндөр үнээр буцаан худалдан авч, төсвийн үргүй зардал гаргадаг байдлыг зогсоох.

### **Хоёр. Аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагч Г.Батжаргал, аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга**

#### **С.Байгалмаа нарт**

1. Төсвийн орлогын мэргэжилтэн төсвийн орлогыг нэмэгдүүлэх бааз суурийг өргөжүүлэх судалгааг хийж, холбогдох нотлох баримтыг албажуулж, орлогыг үндэслэлтэй төлөвлөж байх.
2. Төсвийн зарлагыг төлөвлөхдөө хууль тогтоомжийн хүрээнд холбогдох тооцоо, судалгаанд тулгуурлан, төсвийн хөрөнгийг үр ашигтай төлөвлөж, хэрэгжүүлж байх.
3. Сангийн яамны төсвийн төлөвлөлтийн программд байгууллагуудын 2019 оны батлагдсан төсөв, эх үүсвэрийг зөрүүтэй оруулсан зөрчлийг 2019 оны 10 дугаар сард багтаан арилгах.
4. ТБОНӨХБАҮХАТХ-ийн 5.1.15-д заасан зөвлөх үйлчилгээний ажлыг хэрэгжүүлэхдээ цаашид хуулийн 4 дүгээр бүлэгт заасан журмыг мөрдөж ажиллах.
5. Төсөвт байгууллагууд зардлын гүйцэтгэлийг эдийн засгийн ангиллын дагуу батлагдсан төсвийн хүрээнд “Засгийн газрын удирдлагын мэдээллийн систем”-д тусгагдсан төсвийн хэлбэлзэл, дансны хуулганы дүнтэй тохируулж, зөрчлийг арилган санхүүгийн тайлан, Шилэн дансны цахим хуудсанд үнэн зөв тайлагнаж байгаад аймгийн СТХС хяналт тавьж ажиллах.
6. Аймгийн ЗДТГ-ын СТСХ нь сумдын ИТХ-аар баталсан тогтоолд хяналт тавих, төсөвт байгууллага, ажиллагсдын тоо болон орлого, зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэлийг программд үнэн зөв оруулах, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасан бүрэлдэхүүн тус бүрээр төсвийн гүйцэтгэлийн тайланг

гаргах, төсвийн орлого, зарлагын төлөвлөлт, гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж ажиллах зэрэг өмнөх аудитаар өгсөн зөрчлүүд арилахгүй байгаа тул холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцож, зөрчлийг бүрэн арилгах арга хэмжээ авч ажиллах.

7. Баян-Өндөр, Баянцагаан, Баянговь зэрэг зарим сумдад цагдаагийн хүү торгуулийн данс андуурч нээгдсэн асуудлыг холбогдох газарт тавьж шийдвэрлүүлэх.
8. Аймгийн ЗДТГ-ын орлогын мэргэжилтэн, аймгийн Татварын хэлтсийн орлогын эдийн засагч нарын ажлын уялдааг сайжруулж, татварын орлогын гүйцэтгэлийг үнэн зөв мэдээлж байгаад хяналт тавих.

#### **Гурав.Сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга нарт**

1. Сангийн сайдын 2012 оны 244 тоот тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан загвар маягтын дагуу төсвийн төслийг өргөн мэдүүлж, төсвийн нийт эх үүсвэр, зардлыг хянаж, тооцооллын алдаагүй төсөв баталж байх.

#### **Дөрөв.Аймгийн Татварын хэлтсийн даргын үүрэг гүйцэтгэгч С.Рэнцэндагва танаа**

1. Аймгийн ЗДТГ-ын орлогын мэргэжилтэн, аймгийн Татварын хэлтсийн орлогын эдийн засагч нарын ажлын уялдааг сайжруулж, татварын орлогыг нэр заасан дансанд төвлөрүүлэх, гүйцэтгэлийг үнэн зөв мэдээлж байх.
2. Татварын орлогын гүйцэтгэлийг 2019 оны эхний хагас жилийн байдлаар төрийн сангийн дансны хуулганы дүнгээс зөрүүтэй тайлагнасан алдаа зөрчлийг 2019 оны 10 дугаар сарын 20-ны дотор арилгаж, жил бүр уг алдаа арилахгүй давтагдаж байгаад дүн шинжилгээ хийж, холбогдох арга хэмжээг авч ажиллах.

#### **Тав. Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Ц.Идэрмөнх танаа**

1. Орон нутгийн өмч хөрөнгийг түрээслүүлэхдээ аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 43 тоот тогтоолоор баталсан түрээсийн төлбөрийн жишиг үнийг баримталж, тогтоолын 2.2 дахь заалтыг хэрэгжүүлж орон нутгийн өмчит болон төсөвт байгууллагуудтай хийсэн гэрээнд хяналт тавьж, шаардлагатай бол түрээсийн гэрээг шинэчлэх.
2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөд бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлогыг орон нутгийн төсөвт тухай бүр төвлөрүүлж байх.

Зөвлөмжийн мөрөөр зохиосон ажил, түүний хэрэгжилт, үр дүнг 2019 оны 11 дүгээр сарын 30-ний дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.